



**УЛС ТӨР**  
 “ОФФШОР БҮСЭД ДАНСТАЙ 20 ТӨРИЙН АЛБАН ХААГЧ БАЙГАА”  
 II нүүрт

**ОНИЦЛОХ ХУУДАС**  
 “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ”-Н ХУВЬЦАА АМЬ ОРОХГУЙ НЬ  
 V нүүрт

Дугаарын **60** мөр  
 Гаалийнханд технологийн дэвшил хэрэгтэй байна

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА  
**ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХ ЗУРГААН ЖИЛ БОЛЖ, АРД ТҮМЭН БУС УИХ ТОМИЛОХ НЬ**

–Зөвлөлдөх санал асуулгын үр дүн гарсны дараа бүх нийтийн санал асуулга явуулна–

Н.ПУНЦАГБОЛД  
 Монголчуудын амьдрал нэг үеэ бодвол арай дээрдэж байгаа. Хүмүүс хуримтлал үүсгэж, мөнгөө хурааж, аялж, зугаалж чаддаг болсон байна. Нөгөө талаар хойд, урд хөрс рүү явж, наймаа хийдэг хүмүүс ч олон болсон. Цаашлаад Монгол Улс хоёр хөрштэйгээ найрсаг харилцаагаа эрхэмлэж, аль аль руу нь визгүй зорчиж буй. Мөн өөрийн боломж бололцоог ашиглаж, хил орчмын аялал жуулчлалыг ч хөгжүүлэхээр анхны шанг нь татаж эхэлсэн. Улаанбаатар төмөр замын Аялал жуулчлалын товчооноос тусгай галт тэрэг гаргаж, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх алхмаа хийгээд эхэлсэн.



Б.ӨНӨРТӨГТОХ  
 УИХ-ын хаврын чуулганы эхэнд Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлаар Зөвлөлдөх санал асуулга явуулах шийдвэр гаргаж, УИХ-ын тогтоол баталсан билээ. Улмаар Үндэсний статистикийн байгууллагын санамсаргүй аргаар түүвэрлэсэн 1570 иргэн ажлын хэсгийн боловсруулсан зургаан сэдвийн хүрээнд санал өгөх ажил энэ сарын 12-ноос орон даяар эхэлсэн юм. Эдгээр иргэдээс 750 иргэнийг сонгон авч үндсэн зургаан сэдвийн хүрээний 13 асуудлаар хэлэлцүүлэг мэтгэлцэн өрнүүлэх үйл ажиллагаа өнгөрөгч амралтын өдрүүдэд Төрийн ордонд боллоо. Анхдугаар зөвлөлдөх уулзалтын үйл ажиллагаанд түүврийн аргаар сонгогдсон иргэдээс гадна, Үндсэн хуулийг батлацгааж явсан Ардын их хурлын депутатууд, Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, УИХ-ын дарга М.Энхболд, ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат, Монгол Улсын Ерөнхийлөгч асан П.Очирбат, Үндсэн хуулийг өөрчлөх ажлын хэсгийн ахлагч Д.Лүндээжанцан болон УИХ-ын гишүүд, мэргэжлийн экспертүүд, УИХ дахь намын бүлгийн дарга нар болон парламентад суудалгүй улс төрийн намуудын дарга нар оролцлоо.

Үргэлжлэл нь III нүүрт

ДУУЛИАНЫ ЭРГЭН ТОЙРОНД

**ТАТВАРАА НЭМЭЭД ЭХЭЛЧИХЛЭЭ, ГЭТЭЛ...**

Э.ТУУЛ  
 УИХ 2017 оны төсвийн тодотголыг баталсан билээ. Төсвийн тодотгол батлагдсанаар долоон төрлийн татвар нэмэгдэхээр болсон. Тэдгээр татвараас дөрөв нь энэ жил хэрэгжих бөгөөд өнөөдрөөс гурван төрлийн татвар нэмэгдэж байна. Тодруулбал, хувь хүний орлогын албан татварын хуулийн дагуу 2018 оны нэгдүгээр сарын 01-нээс бүх хадгаламж эзэмшигчдийн хадгаламжийн хүүгийн орлогод татвар ногдуулахаар тусгасан. Харин 2017 оны төсвийн тодотголттой хамт хадгаламжийн хүүгийн орлогод татвар ногдуулах хугацааг наашлуулж, 2017 оны тавдугаар сарын 01-нээс хэрэгжихээр болсон юм.  
 Гэхдээ нийт хадгаламжинд нь 10 хувийн татвар ногдуулах бус, хадгаламжинд тооцож буй банкны хүүгээс 10 хувийн татвар ногдуулна. Мөн өнөөдрөөс цилиндрийн багтаамж нь 1500 см3 ба түүнээс дээш автомашины татвар насжилтаасаа хамаарч нэмэгдэж байна. Өөрөөр хэлбэл, өнөөдрөөс эхлэн гаалиар орж ирж байгаа 4500см3-аас доош хөдөлгүүрийн багтаамжтай суудлын автомашинд үйлдвэрлэсэн оноос хамааруулж, 3-15 хувь буюу 25,000-2,275,000, 4501см3-аас дээш хөдөлгүүрийн багтаамжтай суудлын автомашинд 40-250 гаруй хувь буюу 4,060,000-47,125,000 төгрөгөөр тус тус нэмэгдэнэ. Харин тэжээлт, цахилгаан хөдөлгүүрт болон хийгээр ажилладаг автомашины онцгой албан татварыг 50 хувиар хөнгөлж, эдгээр автомашинд 375,000-6,675,000 төгрөгийн татвар ногдох юм. Үүнээс гадна импортын тамхинд ногдуулах гаалийн татвар нэмэгдэнэ. Өмнө нь импортын албан татвар таван хувь байсныг нэмэгдүүлж, 30 хувь болгосон билээ.  
 Уг нь эдгээр татварууд ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдах асуудлаас үүдсэн. Тэдний тавьсан шалгуурыг хангахын тулд

ДЭЛХИЙ



Б.ДАВААХҮҮ  
 АНУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп ялалт байгуулж, энэ оны нэгдүгээр сарын 20-нд тангараг өргөсөн билээ. Тэрбээр конгрессын ордны өмнө библийн судар дээр зүүн гараа тавьж, баруун гараа өргөн “Доналд Жон Трамп би АНУ-

**Д.ТРАМП ӨӨРИЙГӨӨ АНУ-ЫН ТҮҮХЭН ДЭХ ХАМГИЙН АМЖИЛТТАЙ ЕРӨНХИЙЛӨГЧ ХЭМЭЭВ**

ын Ерөнхийлөгчийн үүргийг чин шударгаар гүйцэтгэж, АНУ-ын Үндсэн хуулийг дээдэлж, сахин хамгаалахын төлөө өөрийн бүх хүч чадлыг дайчлахаа тангараглаж байна. Бурхан надад туслах болтугай” хэмээж, хүчирхэг гүрний 45 дахь Ерөнхийлөгч болсноос хойшхи 100 дахь өдөр нь энэ сарын 29-нд тохиолоо. Д.Трамп 100 дахь өдрөөрөө Пенсильвани мужийн Гаррисбергт илтгэл тавьж, Ерөнхийлөгч болсноосоо хойш хийж хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг танилцуулсан байна.

Үргэлжлэл нь IV нүүрт

ХААН Банк	Авах			Зарах			Хугалгаа хөгжлийн банк	Авах			Зарах		
	АМ.ДОЛЛАР	2410.00	2426.00	ФУНТ	3083.00	3177.00		АМ.ДОЛЛАР	2414.00	2426.00	ФУНТ	3068.00	3186.00
	ЕВРО	2610.00	2677.00	РУБЛЬ	41.40	43.50		ЕВРО	2592.00	2696.00	РУБЛЬ	40.20	45.52
	ИЕН	21.56	21.87	ЮАНЬ	348.60	351.50		ИЕН	21.24	22.16	ЮАНЬ	348.50	351.90

# УЛС ТӨР

## ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

# “ОФФШОР БҮСЭД ДАНСТАЙ 20 ТӨРИЙН АЛБАН ХААГЧ БАЙГАА”

Б.ТОГТОХ

УИХ-ын чуулганы нэрв, баасан гарагийн хуралдааны сэдэв Зөрчлийн тухай хуулийг онилж байлаа. Засгийн газраас оруулж ирсэн уг хуульд сэтгүүлч болон иргэн сошиал суваг болон хэвлэл мэдээлэлээр дамжуулан бусдыг гүтгэсэн тохиолдолд 10-100 сая төгрөгөөр торгох тухай асуудал маргаан дагуулав. Мөн танхай, хулгай зэргийг зөрчилд тооцходоо шаардлагатай гэвэл баривчлах тухай заалт оруулсан нь хоёр намын дунд маргааны сэдэв болж, УИХ дахь АН-ын бүлэг хуралдааныг хаяж гарах шалтгаан болсон юм. Пүрэв гарагт хуралдсан чуулганы хуралдаан үдээс хойш чамгүй маргаан мэтгэлцээн дунд өрнөлөө. Улмаар Зөрчлийн хууль биш жижиг Эрүүгийн хууль боллоо гэх саналыг Ардчилсан намын бүлгээ тавьж, хэлэлцэхийг хойшлуулах санал гаргасан ч УИХ-ын дарга хүлээж аваагүй. Ингэснээр уг хуультай холбоотой зарчмын зөрүүтэй санал хураалт үргэлжилж, зарим зүйл заалтыг унагав. Сэтгүүлч болон олон нийтийн сошиал сувгаар хүн гүтгэсэн гэж үзвэл 10-100 сая төгрөгөөр торгох Ц.Гарамжав гишүүний санал унаж, “гүтгэх” зүйл заалт Эрүүгийн хуульдаа үлдэхээр болжээ. Улмаар хуралдаан завсарлах цаг болсон учраас УИХ-ын дарга хэлэлцүүлгийг баасан гарагт үргэлжлүүлэхээр хойшлуулсан юм. Тэгвэл баасан гарагийн хуралдаанаар хэлэлцүүлгийг үргэлжлүүлж 85 саналын томьёолол бүрээр санал хураалт явуулав. АН-ын бүлэг хуулийг эсэргүүцэн хуралдааныг орхин гарсан ч МАН дангаар ирдэг бүрдүүлэн хуулийг төслийг хэлэлцэн баталлаа. Тухайлбал, оршин суугчийн зөвшөөрөлгүй



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

гэрэл зураг авсан, бичлэг хийсэн бол хувь хүнийг 200 нэгжээр торгох, бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр нууцаар авсан бол албадан сургалтад хамруулахаас гадна 7-30 хоног баривчлах, Бусдын итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг завшсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг 500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуула гээснийг гишүүдийн олонхи дэмжлээ. Мөн ажлын хэсгээс төсөлд эмэгтэйчүүдийн эмч үр хөндөх үйл ажиллагааг эмнэлгийн бус нөхцөлд хийвэл тусгай зөвшөөрлийг цуцлах, 500 нэгжээр торгох, харин тусгай зөвшөөрөлгүй мэргэжлийн бус хүн үр хөндсөн бол 700 нэгжээр торгоно гэсэн заалтыг гишүүдийн олонхи дэмжсэнгүй. Түүнчлэн, санаатай хүнд гэмт хэргийг нуун далдалсан хүнийг 750 нэгжээр торгох заалтыг ажлын хэсэг татаж авлаа. Дээрх саналуудыг хэлэлцэж, улмаар хуулийн төслийг МАН дангаараа хэлэлцэн дэмжиж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох байнгын хороонд шилжүүлжээ.

**Д.Эрдэнэбат,  
Б.Дэлгэрсайхан,  
Д.Цогтбаатар нарын  
мэдээллийг ил болгооч**

Энэ өдрийн хуралдааны

**МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ**

### Намуудын Их, Бага хурлын тов гарчээ

Тун удахгүй монголчууд бид Ардчилсан Монгол Улсын Ерөнхийлөгчөө сонгоно. Тэр ч утгаараа энэ сард парламентад суудалтай улс төрийн намууд ээлжит Их, Бага хурал болон Бага чуулганаа хуралдуулж Ерөнхийлөгчид өрсөлдөх нэр дэвшигчээ тодруулах учиртай. Сонгуулийн тухай хууль ёсоор маргаашнаас эхлэн нэр дэвшигчийг бүртгэж эхэлдэг. Тэгвэл Ардын намынхан энэ сарын 3-нд Бага хурлынхаа товгыг зарлажээ. Бага хурлаас өмнө намын Удирдах зөвлөлөөр нэр дэвшигчээ батламжилж, улмаар Бага хурлын гишүүдээ танилцуулах учиртай. Энэ намаас одоогоор Ардын намын дарга, УИХ-ын дарга М.Энхболд, УИХ-ын гишүүн Ц.Нямдорж, Ө.Энхтүвшин, Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ нарын нэр дуудлагдаж буй. Тэгвэл Ардчилсан намын Их хурал мөн л энэ сарын 6-нд болох бөгөөд үүний өмнө ирэх лхагва гарагт

дараагийн хэлэлцэх асуудал нь УИХ-ын гишүүний асуулгын хариу байв. тодруулбал, УИХ-ын гишүүн М.Оюунчимэгээс “Монгол Улсаас оффшорт нэр холбогдоод буй төрийн албан тушаал хашиж байсан болон оффшор бүсэд өөрийн болон хамаарал бүхий этгээдүүдийн нэр дээр данс эзэмших, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, орлогоо нуун далдлах, татвар төлөхөөс зайлсхийх, мөнгө угаах зэргээр 17 тэрбум ам.долларын хууль бус үйлдлүүдийг гаргасан байж болзошгүй талаарх мэдээлэл бодит эсэх, энэ талаар холбогдох хууль, хүчний байгууллагууд хянаж шалгаж байгаа эсэх, цаашид авах арга хэмжээ”-ний талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг сонслоо. Хуралдаанд Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Энхбаяр, Авлигатай тэмцэх газрын дарга Х.Энхжаргал, Цагдаагийн ерөнхий газрын дарга Ө.Энхтөр болон холбогдох албаны хүмүүс оролцлоо. С.Бямбацогт сайд М.Оюунчимэг гишүүний Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг танилцуулав. Тэрбээр танилцуулахаа, асуултад дурдсан 17 тэрбум ам.доллартай асуудлаар Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газарт мэдээлэл ирээгүй бөгөөд албан ёсоор бүртгэгдсэн болон мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байгаа тохиолдол

байхгүй гэдгийг онцолж байлаа. 2011-2016 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” 27 гэмт хэрэгт мөрдөн байцаах ажиллагаа явуулснаас дараах эрүүгийн хоёр хэрэг нь оффшор бүстэй холбоотой байжээ. Үүнд, “МИАТ” ТӨХК-ийн удирдах албан тушаалтнууд, Монгол Улсын иргэн Б нарын гэмт хэрэг болно гэдгийг дурьдлаа. Мөн шинэчлэн батлагдсан хууль ёсоор оффшор бүсэд данстай бол түүнийгээ хаалгах, эс бөгөөс төрийн албанд ажиллаж эрхээ хасуулж, хуулиар хариуцлага хүлээнэ гэдгийг салбарын сайд онцолсон юм. Хууль зүй, дотоод хэргийн сайдын мэдээлэлтэй холбогдуулж Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Х.Болорчулуун, Д.Тэрбишдагва, М.Оюунчимэг, Ж.Ганбаатар, Г.Занданшатар, Н.Энхболд, Л.Оюун-Эрдэнэ, Б.Дэлгэрсайхан, Ө.Энхтүвшин, Д.Эрдэнэбат, Д.Ганболд нар асуулт асууж, хариулт авав. Тухайлбал, УИХ-ын гишүүн Ж.Ганбаатар “Оффшор бүсэд манайхны 17 тэрбум ам.доллар бий гэж яригдаад байгаа. Энэ нь Монголын хэмжээнд хэт их тоо юм шиг сонсогдоод байна. Энэ асуултад хариулт өгөөч” хэмээлээ. Гишүүний асуултад АТГ-ын дарга Х.Энхжаргал “Оффшор бүсэд Монгол Улсын 49 иргэний мэдээлэл байдаг. Давхардсан тоогоор 29 иргэний 42 аж ахуйн нэгж байгаа гэж одоогоор тогтоогдсон. Тэр 29 хүний 20 нь одоо төрийн албанд

ажиллаж байгаа. Тэднээс байцаалт авсан. Тэдний зарим нь бизнес хийх зорилгоор сонирхож үзсэн, зарим нь оффшор бүсэд байгаа хөрөнгөө Монгол руу оруулаад ирчихсэн байдаг. 17 тэрбум ам.доллар оффшор бүсэд байгаа гэдэг бол тогтоогдох үндэслэлгүй тоо. Харин 29 хүний тухайд оффшорын асуудлаа үндэслэлгүй тоо. Харин 29 хүний тухайд оффшорын асуудлаа үндэслэлгүй гээд, бүх бичиг баримтаа авч ирж, мэдүүлэг өгсөн. “17 тэрбум ам.доллар оффшор бүсэд байна” гэсэн мэдээлэл цацагдан, иргэд жагсаал, цуглаан зохион байгуулж, Авлигатай тэмцэх газарт гомдол, саналаа илэрхийлсэн. Үүний мөрөөр Авлигатай тэмцэх газар өөрсдийн хүч, нөөц бололцоонд суурильж эрэн сурвалжилсан. Энэ мэдээлэл унэн, худал эсэх нь батлагддаггүй. Оффшор бүс гэж татвар маш бөөгөд огт татваргүй, нууцлал маш өндөр, төрийн хүнд сурталгүй, үйлчилгээ шуурхай гэсэн шаардлагыг хангасан бүсийг хэлдэг. Тиймээс энэ бүсээс мэдээлэл авах ямар ч боломжгүй. Харин “Panama Papers”-ийнхэн 11.7 сая мэдээллийг хакердаж, олон нийтэд илчилсэн. Авлигатай тэмцэх газар нь 20 гаруй улстай эрх зүйн туслахаа авахаар хамтран ажилладаг. Гэхдээ нэг улсад хандан бичиг илгээснийхээ дараа ойр, ойрхон сануулахгүй бол харуу ирэхгүй зургаан сар, нэг жил хүртэл харуу ирдэггүй. “Хөөцөлдье”, “эргэдэг хариу хэлье” гэдгээс цааш хэтэрдэггүй. Авлигатай тэмцэх газарт гадаад харилцааны төсөв байдаггүй.

Олон улсын хурал, чуулганд оролцооч, зардлыг нь даая гэсэн тохиолдолд оролцохоос өөрөөр хэтэрдэггүй. Хэрэв оффшор бүсэд данс эзэмших, хуулийн этгээд байгуулахыг хориглоё гэж байгаа бол Авлигатай тэмцэх газрын гадаад харилцааг өргөжүүлэх тал дээр анхаарах нь зүйтэй болов уу” гэсэн хариулт өгсөн юм. Мөн УИХ дахь АН-ын бүлгийн дарга Д.Эрдэнэбат “Төрийн албан хаагчид дунд 20 хүн оффшортой байна гэлээ. Үүнийг яагаад ил болгодоггүй юм бэ? Ганцхан С.Баярцогт руу оффшор гээд дайраад байсан биз дээ. Сү.Батболдын ах, Б.Дэлгэрсайхан, Д.Цогтбаатар нартай холбоотой оффшорын асуудлыг ярих хэрэгтэй шүү дээ” гэв. Ерөнхий сайдад тавьсан асуулгын талаар гишүүд асуулт асууж, хариулт авсны дараа УИХ-ын гишүүн М.Оюунчимэг өөрийн байр сууриа илэрхийллээ. Тэрбээр, “Гадаадын оффшор данс гэхээсээ бонд, концесс гэдэг дотооддоо нуун дарагдуулсан байж болзошгүй 7.4 их наяд төгрөгийн асуудлыг шалгах цаг болжээ. Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Хууль зүй, дотоод хэргийн яам хамтраад Татварын болон Ил тод байдлын тухай зэрэг холбогдох хууль, тогтоомжид өөрчлөлт оруулж, ирэхийг хүсч байна. УИХ ч холбогдох хууль, тогтоомжийг хэлэлцэж, эрх зүйн зохицуулалтыг хийх шаардлагатай” хэмээлээ.

**МММINFO**

**МОНГОЛЫН МЭДЭЭ**

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 90873012**

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба **Н.ПУНЦАГБОЛД 88096454**

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН 96017873**

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**

Маркетинг, зар сурталчлаланы алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710**

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ 99042510**

**Э.САЙНЗАЯА 99197866**

Дугаарыг эрхлэсэн **Э.ЭНХЦЭЦЭГ**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528  
Индекс: 100757

**Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

### Приус машины татварыг хойшлуулах хүсэлт гаргав



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

УИХ дахь АН-ын бүлгийн дарга Д.Эрдэнэбат автомашины Онцгой албан татварын хуулийн хэрэгжих хугацааг хойшлуулах хүсэлтийг Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатад өнгөрөгч баасан гарагт хүргүүлэв. 2017 оны төсвийг тодотгож Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Тиймээс хуулийн дагуу өнөөдөрөөс хос тэжээлт, шингэрүүлсэн хийгээр ажилладаг, цахилгаан тэжээлт автомашины татварын хөнгөлөлтийг 50 хувиар бууруулж, суудлын автомашины хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж, насжилтаас хамааруулж Онцгой албан татварын хэмжээг нэмэхээр болсон билээ. Тэгвэл ийнхүү хуулийг батлагдсанаас хойш иргэд, автомашин импортлуулсан хуулийн хэрэгжих хугацааг хойшлуулах хүсэлтийг удаа дараа ирүүлээд байна. Уг нь олон улсын жишгээр Онцгой албан татварыг хувь хүн, нийгэм, хүрээлэн буй орчинд хортой, сөрөг нөлөө үзүүлдэг бүтээгдэхүүний хэрэглээг хязгаарлах зорилгоор ногдуулдаг. Гэтэл шатахууны зарцуулалт бага, байгаль орчинд ээлтэй, жирийн иргэдийн өдөр тутмын ахуйн хэрэглээ болсон гибрид буюу хос тэжээлт приус автомашины болон шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашинаас онцгой албан татвар авч байгаа нь эдийн засгийн хүндрэлтэй үед иргэдийн халаасанд гар дүрсэн туйлын буруу шийдвэр болсон байна. Тиймээс дээрх хуулийн дагаж мөрдөх хугацааг хойшлуулан 2017 оны аравдугаар сарын 01-ний өдөр болгон өөрчлөх тухай хуулийн төсөл боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, УИХ-д яаралтай өргөн барьж, батлуулахыг хүслээ.

### Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажил эхэллээ

Ерөнхийлөгчийн сонгуультай холбогдуулан дөрөвдүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн шилжилт хөдөлгөөнийг зогсоожээ. Сонгуулийн тухайн хуулийн 66.2 дэх хэсэгт зааснаар “Иргэдийн засаг захиргааны нэг нэгжээс өөр нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг санал авах өдрөөс 60 хоногийн өмнө зогсоож, санал авах өдрийн дараах өдөр сэргээнэ” гэж заасан байдаг. Үүний дагуу иргэдийн шилжилт хөдөлгөөнийг түр хугацаагаар зогсоогоод байгаа аж.

Улмаар зургадугаар сарын 27-ны өдрөөс шилжилт хөдөлгөөн хэвийн болно гэв. Мөн ирэх зургадугаар сард болох Ерөнхийлөгчийн сонгуулийг Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт хүний эрхийн алба /ЕАБХАБ/-ны Хязгаарлагдмал Сонгууль ажиглах хороо ажиглах юм байна. Мөн урт хугацааны 24 ажиглагчийг орон даяар явуулах сонгуулийн үйл ажиллагааг хянуулахаар Монгол Улс ЕАБХАБ-ын

гишүүн орнуудаас хүсэх юм байна. Сонгуулийн санал авах өдөр Сонгууль ажиглах хорооньхон тодорхой хэдэн санал авах байрууд дээр очиж ажиглалт хийх боловч бүрэн гүйцэд, системтэй ажиглалтыг хийх гэнэ. ЕАБХАБ-ын АИХЭА-ны сонгуулийн ажиглалтын арга зүйн стандартын дагуу, ХСАХ нь хэвлэл мэдээллийн хяналтын ажиглалтыг мөн хийнэ гэдгээ Сонгуулийн ерөнхий хороонд мэдэгджээ. Мөн тус байгууллагаас

сонгуулийн ажиглалтын урьдчилсан судалгааны баг хоёрдугаар сарын 21-нээс 24-ний өдрүүдэд Улаанбаатар хотод ажилласан тухай тайлангаа энэ дөрөвдүгээр сарын 25-ны Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлжээ. Судалгааны багийнхан Улаанбаатар хотод ажиллахдаа төрийн болон төрийн бус байгууллагууд, улс төрийн намын удирдлага, иргэд олон нийттэй уулзаж тодорхой шалгуураар үнэлсний үндсэн дээр тайлангаа гаргасан байна.

# ҮЗЭЛ БОДОЛ

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

## ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХ ЗУРГААН ЖИЛ БОЛЖ, АРД ТҮМЭН БУС УИХ ТОМИЛОХ НЬ

–Зөвлөлдөх санал асуулгын үр дүн гарсны дараа бүх нийтийн санал асуулга явуулна–

**Үргэлжлэл.**  
**Түүрч нь I нүүрт**

Мөн энэхүү түүхэн уулзалтыг гадаад, дотоодын 60 гаруй ажиглагч ажиглав. Зөвлөлдөх уулзалтыг нээж УИХ-ын дарга М.Энхболд үг хэлсэн юм. Тэрбээр, “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал зөвхөн парламент, эсвэл санал санаачилга гаргасан хүмүүсийн санаан зоргоор хийх ажил биш бөгөөд энэхүү нэмэлт, өөрчлөлт зайлшгүй шаардлагатай гэж үзвэл “Долоо хэмжигч нэг огтлох” зарчмаар хандах ёстой гэсэн байр суурьтай байгаагаар миний бие УИХ-ын хаврын чуулганы нээлтэд хэлсэн үгэндээ онцолсон. Нэмэлт, өөрчлөлтийг урьдын адил нийт ард түмнийхээ санал

албан ёсоор оролцсон бөгөөд 657 эрэгтэй, 858 эмэгтэй сонгогджээ. Харин хоёрдугаар шатанд 359 эрэгтэй, 426 эмэгтэйг сонгож авсан байна. Нэгдүгээр шатны санал асуулгад оролцогчдын хамгийн ахмад нь нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэн 91 настай Г.Даваа гуай байсан бол хоёр дахь шатанд сонгогдсон хүмүүсийн хамгийн ахмад нь 85 настай Сонгинохайрхан дүүргийн харьяат Д.Долгорсүрэн гэх эмэгтэй байсан аж. Хоёр шатны санал асуулгын хамгийн залуу хүмүүс нь 18 настай бол хоёр дахь шатанд 18 настай дөрвөн оролцогч оролцож байгаа сонирхолтой тоон мэдээг зохион байгуулагчид өглөө. Мөн огт боловсролгүй 19 иргэн түүврийн аргаар сонгогджээ.

хийж, улмаар 49 хэсэг эдгээр сэдвүүдээр хэлэлцүүлэг өрнүүлжээ. Ерөнхийлөгчийн эрх үүргийг тодорхой болгох сэдвийн хүрээнд Ерөнхийлөгчийг нэг удаа зургаан жилийн хугацаагаар УИХ-ын өргөтгөсөн хуралдаанаар сонгодог болох, ард түмнээс бус өргөтгөсөн хуралдаанаар сонгодог болох. Нөгөө талаар нэг удаа сонгогдохыг зөвхөн нэг удаа хэмээн өөрчлөх. Өргөтгөсөн хуралдаанд УИХ-ын гишүүдээ гадна аймаг, нийслэл, хотын ИТХ-ын нийт гишүүд орно хэмээжээ. Хоёрдугаарт, Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн хууль санаачлах, Засгийн газарт чиглэл өгөх зарилг гаргах эрхийг хасах тухай заалтыг хэлэлцэв. Иргэд ард түмний эрх мэдлийг булааж байна хэмээн эсэргүүцэж харин

Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах үүрэг бүхий Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөтгөх, шүүгч, Ерөнхий шүүгчийг томилох томилооны зарчмыг тодорхой болгох гэсэн гурван саналыг тусгажээ. Энэ өдөр хэлэлцсэн гурван сэдвийн хамгийн сонирхолтой нь дээд, доод танхимтай болох тухай асуудал байв. Ж.Мөнхбат дарга энэ сэдвийг хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр танилцуулга хийлээ. Манайх шиг улс төрийн тогтолцоотой 45 улс орон байдаг 15 хоёр танхимтай парламент бүрдүүлжээ. Харин парламентын хоёр танхимыг бүрдүүлэхдээ дээд танхимыг томилгоо, сонгууль, томилгоо болон сонгуулийн хосолмол хэлбэрээр бүрдүүлдэг байх, харин доод танхимыг ард түмний төлөөлөл болж, бүх нийтийн чөлөөтэй, шууд сонгуулиар бүрддэг байхаар санал боловсруулсан аж. Үндсэн хуулийн өөрчлөлтөд энэ санал тусвал Улсын бага хурлын гишүүнийг 51, Ардын их хурлыг 501 төлөөлөгчтэй байхаар зохицуулалт хийх гэнэ. Энэ сэдвийн хүрээнд танхимд чамгүй халуухан маргаан өрнөв. Тухайлбал, “Монгол Улсын гавьяат хуульч, Академич Ж.Амарсанаа хоёр танхимтай болно гэвэл Үндсэн хуулийн 70 зүйл, 99 хэсгийн 50 гаруй зүйл нь өөрчлөгдөнө. Шинэ Үндсэн хууль багтаагдахад хүрнэ. Өмнө нь дөрвөн удаа хэлэлцүүлэхэд нэг танхимтай байна гэдэг тогтчихсон. Амьдралын 20 гаруй жил явж ирсэн хэвшлийг одоо өөрчлөнө гэж болгожгүй. Яагаад ийм асуудал ороод ирчихсэн нь сонин байна” хэмээн бухимдав.

орлуулах шаардлагатай юу, үгүй юу гэдэг шийдвэрээ гаргаад явах учиртай. Энэ бүхний үр дүнг Үндсэн хуульд заавал өөрчлөлт оруулна гэсэн үг биш гэж ойлгох хэрэгтэй. Яагаад гэвэл түүвэр аргаар хийсэн судалгааны үр дүнд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн үр дүн гарах боломжтой

### М.Оюунчимэг: УИХ-ын гишүүн Засгийн газрын сайдын албыг давхар хаших хэрэггүй



/УИХ-ын гишүүн/

–Энэхүү санал асуулгад иргэдийн идэвх үнэхээр их байна. Иргэдийн зүгээс УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүний албан тушаалтыг давхар хаших ёсгүй. УИХ-ын гишүүн хууль тогтоох, сонгогчидтой уулзах, хууль нь хэрэгжиж байна уу, үгүй юу гэдэг дээр хяналт тавих ажилтай байдаг. Харин Засгийн газрын гишүүн бүхэл бүтэн яам удирдаад явдаг тул ажил цалгардах сөрөг тал байна. Тиймээс УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг давхар хаших хэрэггүй гэдэг байр суурийг илэрхийлж байна. Энэ бол иргэдийн санал бодлын нэг хэсэг нь юм. Зарим хүмүүс Анхдугаар зөвлөлдөх санал асуулгын үр дүнг эцсийн үр дүн гэж хараад байна. Гэтэл энэ бол шаг дараатай явах арга хэмжээнүүдийн эхний хэсэг юм. Өнөөдөр оролцсон иргэн бүрээс тусгайлан санал авна. Ингээд санал авах, баримт бичгийг хураах зэрэг ажиллагааг бүгдийг нь баримтжуулж, камерын бичлэг хийнэ. Хэрэв дараа нь ямар нэгэн маргаантай асуудал гарч ирэх юм бол камерын бичлэгээ баримт болгон ашиглах юм. Бүхий л үйл явц ил тод шударга явж байгаа.

### Н.Жанцанноров: Би түүврийн аргад итгэсэн



/Зөвлөлдөх зөвлөлийн гишүүн/

–МАН, АН хоёр ойролцоо суудал авсан үедээ Үндсэн хуулийн өөрчлөлт хийчих байх гээд найддаг. Гэтэл яаж ч чадахгүй, хоорондоо тохиролцож чадахгүй байсаар өдий хүрлээ. Уг нь тэгсэн бол биесээ хардаж, тэрний энэний эрх ашгийн төлөө гэж хардахгүй байх байсан. Одоо нэг нам нь олон суудалтай үедээ хийж гээд оролдоод эхэллээ. Тэгэхээр өөрсдийнхөө эрх ашгийн төлөө өөрчлөлт оруулчихна гээд хардах юм. Үндсэн хууль манай улсын хөгжлийг ямар нэг хэмжээгээр урагшуулахад тохирох, тохирохгүй зүйл байгаа бол өөрчлөлт хийхээс аргагүй. Тохирох, тохирохгүй зүйл байгаа өөрчилбөл болох нь, хэрвээ үүнийг тэгвэл тэгэх нь ээ гээд яах вэ гэдэг асуудалтай тулгараад үүнийгээ асууя гэсэн. Асуух хууль гаргасан. Үүндээ иргэдээ түүврийн аргаар оролцуулж байна. Би түүврийн аргад нь итгэсэн. Аль нэг намын нөхөр орж ирээд дарга, даамлынхаа заавраар ингэж хэлнэ, тэгж хэлэхгүй гэсэн зүйл алга. Боловсролтой, боловсролгүй бүх иргэдийг оролцуулж байгаад харин ч олзуурхсан. Хэдхэн намын дарга нар суугаад Үндсэн хууль өөрчлөх гээгүй байна шүү дээ.



Гэрэл зурагийг Г.АРГУУЖИНИ

бодол, хүсэл зоригт тулгуурлан, тэднээсээ асууж, эрдэмтэн судлаачид, Үндсэн хууль тогтоогчид, улс төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог хангаж, ил тод байдал, зөвлөлдөх ардчиллын зарчмыг бүрэн хэрэгжүүлж хийх учиртай гэж үзэж байна” хэмээсэн юм. 2000 оноос хойш УИХ-ын нэр бүхий гишүүд найман удаа Үндсэн хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл өргөн мэдүүлсэн байдаг аж. Мөн МАН-ын бүлгээс байгуулсан ажлын хэсэг судалгаа хийж үзэхэд хамрагдсан иргэдийн олонхи нь шинэ зохицуулалт хийх нь зүйтэй гэж үзсэн байна. Тухайлбал, Монгол Улсад хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийн тэнцвэрт байдал, хоорондын уялдаа холбоо бүрэн хангагдаагүй гэж 96.7 хувь нь, УИХ-ын бүтэц, зохион байгуулалт өнөөгийн нөхцөлд тохирохгүй байна гэж 73.1 хувь нь, Засгийн газрын гишүүн нэг эерэг УИХ-ын гишүүн байх нь буруу гэж 51.5 хувь нь үзжээ. Түүнчлэн Ерөнхий сайд Засгийн газраа өөрөө бүрдүүлдэг байх нь зөв гэж 57.3 хувь нь, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг ямар нэгэн хэмжээгээр өөрчлөх нийгмийн шаардлага бий болсон гэж 79.3 хувь нь саналаа илэрхийлжээ.

### Ерөнхий сайд танхимаа бүрдүүлнэ

Зөвлөлдөх санал асуулгад оролцож буй 700 гаруй иргэнийг 15 хүнтэй 49 бүлэгт хувааж, үндсэн зургаан сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлсэн. Хуралдааны эхний өдөр “УИХ, Засгийн газрын эрх мэдлийн хяналт-гэнцрийг хангах” талаар хэлэлцүүлэг өрнүүлэв. Энэ сэдвийн хүрээнд Ерөнхий сайд танхимаа өөрөө бүрдүүлж, томилгох, чөлөөлөх эрх мэдэлтэй байх, Засгийн газрын гишүүдийн гуравны нэгээс дээшгүй хувь нь УИХ-ын гишүүн байж болохоор хязгаар тогтоох, Засгийн газрын бүтцийг Үндсэн хуулиар тогтоох буюу яамдын нэрийг Үндсэн хуульд тусгах гэсэн гурван сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнөж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үед шинжээчид иргэдийн асуултад хариулт өгөв. Нэгдүгээр сэдвийн шинжээчээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Лүндэндорж, УИХ-ын гишүүн асан М.Батчимэг, доктор Ч.Энхболд, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш О.Мөнхсайхан нар оролцлоо. Иргэд шинжээчдээс Ерөнхий сайдын эрх мэдлийг нэмэх нь ямар эерэг талтай, нөгөө талаар эрх мэдлийн давуу байдал сөрөг үр дагавар учруулах эсэхийг тодрууллаа. Энэ асуулгад УИХ-ын гишүүн асан М.Батчимэг “Ерөнхий сайд нь танхимаа өөрөө бие даан бүрдүүлбэл харуцлага нь сайжирдаг. Учир бүх харуцлага өөрийн толгой дээр байгаа учраас Засгийн газрын гишүүнээр мэргэжлийн хүнийг томилно” гэсэн хариулт өглөө. Харин яамдын тоог Үндсэн хуульд тусгах талаар шинжээчид “ийм өөрчлөлтийг хийвэл сонгуулийн дараа яамдыг нэгтгэх, татан буулгах асуудал гарахгүй, улмаар бүтцийн өөрчлөлт нэрээр төрийн албыг буцигнуулж, төрийн албан хаагчдыг олноор нь холбох, солих үзэгдлийг хаахад ач холбогдолтой” гэсэн тайлбар өглөө. Нэгдүгээр сэдвийн дараа УИХ-ын гишүүн Ж.Батзандан Ерөнхийлөгчийн эрх мэдлийг тодорхой болгох, ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат “Засаг захиргаа, нутгийн удирдлагын тогтолцоог төгөлдөржүүлэх” гэсэн хоёр, дөрөвдүгээр сэдвээр танилцуула

ч Ерөнхийлөгчийн засаглалтай болох тухай санал гаргаж байлаа. Харин ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбатын хэлэлцүүлсэн дөрөвдүгээр хэсэгт Үндсэн хуульд баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга дөрвөн жилийн хугацаагаар томилох асуудлыг тусгах юм. Дээрх сэдвийн хүрээнд мөн л эерэг, сөрөг шүүмжлэл өрнөснөөр энэ өдрийн хэлэлцүүлэг өндөрлөв.

### Их, бага танхимтай байх нь зөв, буруу

Зөвлөлдөх санал асуулгын хэлэлцүүлэг хоёр дахь өдрөө буюу өчигдөр Төрийн ордын Их танхимд үргэлжилж үлдсэн гурван сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлжээ. Хэлэлцүүлгийн гуравдахь сэдэв нь “Төрийн хариуцлага, сахилга, шударга ёсыг бэхжүүлэх, хууль хэрэгжүүлэх тогтолцоог сайжруулах” тухай. Энэ сэдвийг УИХ дахь АН-ын бүлгийн дарга Д.Эрдэнэбат танилцуулсан. Гурав дахь сэдвийн хүрээнд, төрийн албаны Зөвлөлийн улс төрөөс хараат бус, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх мэдлийн байгууллага болгох, Төрийн жинхэнэ албыг мэргэшсэн, тогтвортой, шатлан дэвших зарчимд шилжүүлэх болон төрийн алба улс төрөөс ангид байна гэж өөрчилжээ. Түүнчлэн, төрийн албан хаагчийг улс төрийн шалтгаанаар ялгаварлан гадуурхах, сонгуулийн үр дүнгээс хамаарч ажлаас халах, хуульд зааснаас бусад үндэслэлээр албан тушаал, зэрэг дэвийг бууруулахыг хориглох заалтыг Үндсэн хуульд нэмж оруулахаар болжээ. Харин Ж.Батзандан гишүүний танилцуулсан тавдугаар сэдэв нь “Улс төрөөс хараат бус, мэргэшсэн, чадварлаг, нэрхүндтэй төрийн албыг бэхжүүлэх” тухай байсан юм. Энэ хүрээнд Үндсэн хуульд Улс төрөөс ангид төрийн хариуцлага, сахилгыг дээшлүүлэх Үндсэн хуулийн байгууллага бий болгох, Төрийн хариуцлагыг дээшлүүлэх, авлигатай тэмцэх бодлого, хэрэгжилтийг хангах, нийгмийн шударга ёсыг сахин хамгаалах байгууллагыг улс төрийн нөлөөлөөс ангид, хараат бус, бие даасан байгууллага болгон зохион байгуулах,

### “Эцэг” хуулийн өөрчлөлтийн талаар хэн юу хэлэв

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар зохион байгуулж буй анхдугаар зөвлөлдөх санал агуулгад хөндлөнгийн хяналт тавьж буй Зөвлөлдөх зөвлөлийн гишүүд болон иргэд, мөн Ардын их хурлын депутатууд, парламентад суудалтай болон суудалгүй намын дарга, УИХ-ын гишүүд Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн асуудлаар байр сууриа илэрхийлснийг тоймлон хүргэе.

### Ц.Сарантуяа: Хэлэлцүүлэг хийгээд л Үндсэн хуулийг өөрчлөх юм биш



/МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, Үндсэн хуулийн цэцийн гишүүн асан/

–Иргэдийн оролцоог хангахын хувьд өргөн боломж олгосон юм байна гэж харлаа. Энд нийгмийн бүх давхаргын төлөөлөл иржээ. Харагдахуйц хөгжлийн бэрхшээлтэй, дөнгөж хүүхэд төрүүлээд удаагүй бүсгүйчүүд, бичиг үсэг сайн мэдэхгүй иргэд, оюутнууд, малчид байна. Тиймээс оролцоог сайн хангаж чадсан гэж хэлэхээр байна. Бичиг үсэг сайн мэдэхгүй хүмүүст нэг хэсэгт орсон бусад хүмүүс нь хэлж өгч, тусалж байна. УИХ-ын Тамгын газар зохион байгуулалтын нарийн хийж байна. Бүх ажил хөтөлбөрт заасан цаг, хугацааны дарааллаар явагдаж буй учир хоёр өдрийн дотор төлөвлөсөн бүх ажил бүрэн дуусах бололцоотой нь харагдлаа. Нэгдсэн тайланг санал асуулгын үрдүнд тулгуурлан боловсруулаад, УИХ-аас тогтоосон хугацаа буюу тавдугаар сарын 06 гэхэд зөвлөмж гаргаж, УИХ-д өргөн барина. Зөвлөмжийг үндэслэлд УИХ Үндсэн хуульд өөрчлөлт

Дугаарын 60 мөр

Гаалийнханд технологийн дэвшил хэрэгтэй байна

Үргэлжлэл. Түүрч нь I нүүрт

Энэ ажлыг зөв менежменттэй хийж чадвал манай улсад л хэрэгтэй. Тэгвэл хэдэн сэтгүүлч өнгөрсөн хоногуудад УБТЗ-ын АЖТ-ны тусгай галт тэргээр Эрээн хот руу явчихаад ирлээ. Улаанбаатараас шууд Эрээнд очдог, хурдан шуурхай явдаг галт тэргээ. Манайхны ихэнх нь Замын-Үүд хүртэл галт тэргээр явдаг, цаашаа машинаар гардаг. Бөөн дараалал, дугаарлалт. Харин Эрээнд шууд очдог галт тэргээ үнэхээр амар юм. Яах вэ, иргэд явахад үнийн хувьд л бага сага ялгаатай байх. Гэхдээ хоёр тийшээ явахад манай гаалийнхан нэлээд цаг авч, иргэдийг саатуулсан. Тэд ажлаа хийж, шалгах ёстойгоо шалгах нь зөв. Хамгийн гол нь манай гаалийнханд технологийн дэвшил дутмаг байна. Галт тэргэнд хэдэн байцаагч орж ирээд, иргэдийн гадаад паспортыг хураагаад аваад явах юм. Тэгээд л цаг гаруй болж байгаа. Эрээн рүү явахад ч, буцаад Улаанбаатар руу эргэхэд ч тийм л юм болсон. Учир нь галт тэргийг цаг гаруй саатуулж, иргэдийн гадаад паспортыг компьютерт оруулж, шалгаж байгаа нь тэр. Улаанбаатараас Эрээн рүү ороход шалгана. Бүх хүний паспортыг шүү дээ. За Хятад руу ороход ч яах вэ, тэртэй тэргүй гаалиар нь гараад, шалгуулаад явчихна. Компьютер нь хэмжээнүүдийн эхний хэсэг юм. Өнөөдөр оролцсон иргэн бүрээс тусгайлан санал авна. Ингээд санал авах, баримт бичгийг хураах зэрэг ажиллагааг бүгдийг нь баримтжуулж, камерын бичлэг хийнэ. Хэрэв дараа нь ямар нэгэн маргаантай асуудал гарч ирэх юм бол камерын бичлэгээ баримт болгон ашиглах юм. Бүхий л үйл явц ил тод шударга явж байгаа.

Н.Жанцанноров: Би түүврийн аргад итгэсэн

–МАН, АН хоёр ойролцоо суудал авсан үедээ Үндсэн хуулийн өөрчлөлт хийчих байх гээд найддаг. Гэтэл яаж ч чадахгүй, хоорондоо тохиролцож чадахгүй байсаар өдий хүрлээ. Уг нь тэгсэн бол биесээ хардаж, тэрний энэний эрх ашгийн төлөө гэж хардахгүй байх байсан. Одоо нэг нам нь олон суудалтай үедээ хийж гээд оролдоод эхэллээ. Тэгэхээр өөрсдийнхөө эрх ашгийн төлөө өөрчлөлт оруулчихна гээд хардах юм. Үндсэн хууль манай улсын хөгжлийг ямар нэг хэмжээгээр урагшуулахад тохирох, тохирохгүй зүйл байгаа бол өөрчлөлт хийхээс аргагүй. Тохирох, тохирохгүй зүйл байгаа өөрчилбөл болох нь, хэрвээ үүнийг тэгвэл тэгэх нь ээ гээд яах вэ гэдэг асуудалтай тулгараад үүнийгээ асууя гэсэн. Асуух хууль гаргасан. Үүндээ иргэдээ түүврийн аргаар оролцуулж байна. Би түүврийн аргад нь итгэсэн. Аль нэг намын нөхөр орж ирээд дарга, даамлынхаа заавраар ингэж хэлнэ, тэгж хэлэхгүй гэсэн зүйл алга. Боловсролтой, боловсролгүй бүх иргэдийг оролцуулж байгаад харин ч олзуурхсан. Хэдхэн намын дарга нар суугаад Үндсэн хууль өөрчлөх гээгүй байна шүү дээ.



# ОНЦЛОХ ХУУДАС

## Сенсаацийн эргэн тойронг

# “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ”-Н ХУВЬЦАА АМЬ ОРОХГҮЙ НЬ

Монгол Улсын иргэн бүр “Эрдэнэс Тавантолгой” компанийн 1072 ширхэг хувьцааг авсан. Яг ч авсан гэхэд хэцүү, төр өгөх дүр үзүүлсэн. Зарим нэг азтай нь, тухайлбал, ахмадууд гэхэд сая төгрөгөө авчихсан. Зарим оюутнууд сургалтын төлбөртөө зарцуулсан. Харин 2016 оны сонгуулийн өмнө төр мөнгө гаргаж, иргэдийн хувьцааны цөөн хэдийг нь худалдаж авсан. Ингээд үнэ хүрээд байхаар яг бидний хувьцаа мөн ч юм шиг. Гэтэл нөгөө талаар бид энэ хувьцааны ногдол ашиг гэж сохор зоос ч авч чадаагүй. Төр засгийнхан л хамаг асуудлыг шийдээд, Хятадын компаниас өч төчнөөн сая ам.доллар зээлчлэхэд, түүнийхээ өрийг нүүрсээр дарж ч байх шиг. Тэгвэл тэдний “Чалько” компаниас зээлсэн олон сая ам.долларын ашиг гэж бидэнд юу ирлээ. “Хүний хөгжил сан”-гийн 21 мянга уу. Энэ мэт ээдрээтэй асуудлууд маш олон байна. Гэтэл саяхан “Эрдэнэс Тавантолгой”-н хувьцаа эзэмшигчдийн хурал боллоо. Энэ мэт асуудлыг “Монголын мэдээ” сонин “Онцлох хуудас” булангаараа онцолж байна.

### “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ”-Н 2.5 СЯА ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧЭЭС 64 НЬ Л ХУРАЛДАА ИРЛЭЭ

**2017.04.28:** “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал дөрөвдүгээр сард багтаж болно гэж байснаараа боллоо. Энэ талаар хэвлэлүүд “Эрдэнэс таван толгой (ЭТТ) компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал өнөөдөр өглөө тус компанийн байранд болов. Хурлыг тус компанийн толгой компани болох “Эрдэнэс Монгол”-ын гүйцэтгэх захирал С.Түмэнцогт даргалан явууллаа. Өмнөх жилүүдийн хувьцаа эзэмшигчдийн хуралтай харьцуулахад энэ удаад харьцангуй олон буюу 64 иргэн хуралд оролцлоо. Өнгөрсөн онд 10, түүний өмнөх онд зургаан иргэн хуралд оролцсон гэж ЭТТ ХК-ийн захирал Д.Ариунболд хэлэв. Гэсэн ч хурлын зарыг хангалттай түгээгээгүй, ердөө 30 минутын хугацаанд хуралд оролцох иргэдийг бүртгэсэн, хурлын танхим жижиг байна, хурлыг хаалттай явуулж байна гэх шүүмжлэлийг эдийн засагч Л.Наранбаатар хэлэв. Мөн тэрбээр хурлын өрөөний ЗГ сүлжээг хаасанд бухимдан, компанийнхаа ажилчдаар энэ танхимыг дүүргэсэн байна гэсэн юм. Өнөөдөр болсон хурлаар “Эрдэнэс таван толгой” компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг гүйцэтгэх захирал Д.Ариунболд танилцуулав. Дараа нь эдгээр тайланд өгсөн ТУЗ-ын дүгнэлтийг уншлаа. Дүгнэлтэд ЭТТ компанийн удирдлага зүтгэл гарган ажиллаж, оновчтой шийдвэр гаргасан гэж Д.Ариунболд захирал болон түүний багийг магтжээ. Өнөөдрийн хуралд ТУЗ-ийн дарга У.Бямбасүрэн оролцоогүй. Тэрээр гадаад томиллоттой яваа аж. Мөн ТУЗ-ийн гишүүн Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал хуралд оролцоогүй юм” хэмээн мэдээлжээ.

### Г.ГАНБОЛД: ИРЭХ ЖИЛЭЭС ИРГЭДЭД НОГДОЛ АШИГ ТАРААХААР ТӨЛӨВЛӨН АЖИЛЛАЖ БАЙНА

**2017.04.23:** “Хөрөнгө оруулагч үндэстэн” чуулга уулзалт өнгөрсөн сарын 23-нд болж, Санхүү, хөрөнгийн зах зээлд ажиллаж байгаа шилдэг компаниуд нэг дор цуглаж, бизнесээ хэрхэн хөгжүүлэх, хөрөнгө оруулалт хэрхэн татах, тулгамдаж буй хүндрэл бэрхшээлээ ярилцсан билээ. Энэ үеэр “Эрдэнэс-Монгол” компанийн дэд захирал Г.Ганболд “Нэгдүгээр улиралд “Эрдэнэс-Тавантолгой” компани татварын дараах ашгаас 80 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. Үүний 67 тэрбум төгрөгийг улсын төсөвт шууд төвлөрсөн. “Эрдэнэс-Тавантолгой” компани ашигтай ажиллах зам руугаа орсон. Жилийн эцэст 260 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Ирэх жилээс компани иргэдийн эзэмшиж байгаа хувьцаанд ногдол ашиг тараах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Иргэдийн хувьцааг бүртгэх, нэрийн данс нээх ажлыг хийж эхэлсэн” хэмээн ярьжээ.

### Л.НАРАНБААТАР: “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ”-Н УДИРДЛАГУУД КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧИЖ БАЙНА

**2017.04.06:** “Эрдэнэс Тавантолгой” компани жижиг хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг зөрчиж байна гэсэн үндэслэлээр эдийн засагч Ч.Ганхуяг, уул уурхайн эдийн засагч Л.Наранбаатар, хуульч Б.Баяр нар шүүхэд хандана гэж мэдэгдэж байсныхаа дагуу энэ сарын 3-нд Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандсан билээ. Энэ талаараа судлаач Л.Наранбаатар “Хувьцаа эзэмшиж байгаа 2.5 сая иргэн болон хувьцааг нь нэрлэсэн үнээр нь худалдаж авсан 533 аж ахуйн нэгжийг “Эрдэнэс Тавантолгой” компанийнхан мэдээллээр үл хангах, хуралд оролцоход саналын эрхгүй байгаа, гол хувьцаа эзэмшигчдэдээ мэдэгдэхгүйгээр томоохон хэцэл хийж буй зэрэг нь Компанийн тухай хууль зөрчиж байгаа юм. Үүнийг үндэслэл болгон шүүхэд хандлаа. Бид энэ талаар өмнө нь иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэж байсан. Түүний хүчээр ахиц гарсан зүйл бий. Тухайлбал, “Эрдэнэс Тавантолгой” компани энэ сарын 28-ны өдөр хувьцаа эзэмшигчдийнхээ хурлыг хийхээр зарласан. Хувьцаа эзэмшигчдэдээ компанийн үйл ажиллагаа, санхүүгийн мэдээллээ хүргэхээр болсон байна. Гэхдээ иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхгүйгээр оролцох боломжтой гэжээ. Ингэж болохгүй. Иргэд энэ хуралд саналын эрхтэй оролцох ёстой” хэмээн ярьсан юм.

### “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ”-Н ХУВЬЦААНЫ АСУУДЛААР ЗАСГИЙН ГАЗАРТ ШААРДЛАГА ХҮРГҮҮЛНЭ

**2017.03.07:** 2017 он гарахтай зэрэгцээд “Эрдэнэс Тавантолгой” компанийнхан Хятадын “Чалько” компанид өгөх өрөө эхний улиралдаа багтааж дуусгах талаар ярьж эхэлсэн. Цаашлаад нүүрсний үнэтэй холбоотой өч төчнөөн асуудал ч ургаж гарч ирсэн билээ. Тэгвэл энэ мэт асуудлууд ид яригдаж байх үед буюу гуравдугаар сард Ч.Ганхуяг, уул уурхайн эдийн засагч Л.Наранбаатар, хуульч Б.Баяр нар хамтран сэтгүүлчдэд мэдээл хийсэн юм. Мэдээллийн үеэр ард түмэн, ААН-үүдэд тараасан “Эрдэнэс Тавантолгой”-н хувьцаа өдийг хүртэл амьтай болгох чиглэлд Засгийн газрын зүгээс анхаарахгүй буйг онцолж, холбогдох асуудлаар төрийн байгууллагуудад хандах болсноо мэдэгдсэн юм. Мөн хэвлэлийн бага хурлын үеэр эдийн засагч Л.Наранбаатар “ЭТТ 100 төгрөгийн орлого олохын тулд 136 төгрөгийн зарлагаддаг. Үүнийг орон нутгийн буюу жижиг ТТ-н зардалтай харьцуулбал 51 хувь, Энержи ресурсынхаас 106 дахин өндөр. 2011 оноос хойш нийт 24.2 сая тонн, сайн чанарын нүүрсийг сорчилж олборлосон. Хэрэв энэ барга барилаар үргэлжлүүлэн ажиллавал уурхайн үр ашигтай нөөц найман жилийн дараа дуусна. Компанийн алдагдал 453 тэрбум төгрөгт хүрсэн. Нийт зээл нь 822 тэрбум төгрөг бөгөөд үүний 70 хувийг Хөгжлийн банкны зээл бүрдүүлж байна. Чалкогийн өр нийт зээлийн наймны нэгийг эзэлдэг” хэмээн мэдээлсэн юм. Засгийн газарт дээрх зөрчил дутагдлуудыг арилгаж, хувьцаа эзэмшигчдийн эрхийг эдлүүлэх асуудлаар шаардлага хүргүүлснээр тодорхой үр дүнд хүрнэ гэж тооцоолсон байна. Улмаар төр засгийн зүгээс уг асуудлыг тодорхой хүрээнд шийдвэрлэж өгөхгүй бол иргэний бол захиргааны хэргийн шүүхэд хандах бүрэн үндэслэл бий гэж хэвлэлийн хуралд оролцогчид тодотгож байсан юм. Манай улсад үйл ажиллагаа явуулдаг, бүхий л ХК дөрөвдүгээр сард багтаан хувьцаа эзэмшигчдийнхээ хурлыг зарладаг. Ингэхдээ хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр урьдчилан зарлах үүрэг хүлээдэг. Иймд энэ удаагийн хурлын зарыг эртнээс түгээн, иргэдийг хуралд оролцуулан, мэдээллээр хангахыг хэвлэлийн бага хурал зохион байгуулагчид уриалсан билээ.

### “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ӨРӨӨ БАРАГДУУЛЛАА

**2017.03.30:** Хэдэн жилийн турш яригдсан “Чалько” компанийн өрийг өнгөрсөн сарын 1-ний өдөр гэхэд дарна гэж мэдээлж байсан. Тэгвэл гуравдугаар сарын 30-ны өдөр өрийг дарсан талаараа “Эрдэнэс Тавантолгой”-н зүгээс мэдээлсэн. Энэ талаар хэвлэлүүд “БНХАУ-ын Чалко компанид төлөх өрөө 100 хувь барагдуулсан талаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирал Д.Ариунболд өнөөдөр Төрийн ордонд мэдээлнэ. Тус компани энэ оны долоон сард Чалкод төлөх өрийг дуусгана гэж тооцоолж байсан ч ийнхүү эрт барагдуулжээ. 2011 онд Ерөнхий сайд Сү.Батболдын Засгийн газрын байгуулсан гэрээ зургаан жилийн дараа ийнхүү дуусгавар боллоо. Энэ гэрээг байгуулснаар манай улс Чалкогоос урьдчилгаа төлбөрт 250 сая ам.доллар авсан. Гэвч энэ мөнгийг “Хүний хөгжил сан”-д шилжүүлэн, иргэн бүрт олгодог 21 мянган төгрөгийн халамжид зарцуулсан юм. Уг нь нүүрс угаах буюу баяжуулах үйлдвэр барьсан бол бодит өгөөжийг нь бүх нийтээрээ хүртэх байлаа” хэмээн мэдээлж байлаа.



## Сэтгүүлчийн өнцөг

# “АМЬГҮЙ” ХУВЬЦААНЫ ЭЗЭМШИГЧИД ХУРАЛДАХ ЭРХТЭЙ ЮУ

Н.Пунцагболд

“Эрдэнэс Тавантолгой” бол 100 хувь төрийн мэдлийн компани биш. Учир нь ААН-үүд, иргэд энэ компанийн хувьцааны тодорхой хувийг эзэмшиж байгаа. Тиймдээ ч аливаа асуудалд нь оролцож, санал болгоо илэрхийлэх эрхтэй. Мэдээж хувьцаа эзэмшиж байгаа иргэн бүр асуудалд нь оролцох боломжтой. Угаасаа оролцож ч чадахгүй. Тийм болохоор тодорхой төлөөллийг оролцуулдаг байх хэрэгтэй юм биш үү. Гэтэл өнгөрсөн сарын 28-ны өдөр болсон хувьцаа эзэмшигчдийн хуралд ердөө л 64 хүн оролцсон байна. ТУЗ-ийн 7, 8 хүн, хараат бус гишүүд. За тэгээд бусад нь бараг тус компанийн ажилчид юм биш үү. Зарим судлаачид тэгж бухимдаж байна билээ. Энд хэд хэдэн тодорхой бус зүйл байгаа. Нэгдүгээрт, “Эрдэнэс Тавантолгой” хувьцаа гаргасан нэр зүүсэн л болохоор ХК биш ХХК-нар үйл ажиллагаа явуулж байгаа. Судлаач Л.Наранбаатарын ярьсныг дахиад иш татъя. Тэрбээр “Эрдэнэс Тавантолгой” нь

хувьцаат компани нэртэй боловч одоогоор ХХК хэлбэртэй байгаа. Компанийн тухай хууль шинэчлэгдэж, хувьцаат компани нь нээлттэй болон хаалттай хэлбэртэй байна гэж тусгасан. Тиймээс “Эрдэнэс Тавантолгой”-н дүрмийг Компанийн тухай хуульд нийцүүлэн, улсын бүртгэлд бүртгүүлэх ёстой. Ингэснээр 2.5 сая иргэн, 533 аж ахуйн нэгж тус компанийн хувьцаа эзэмшигчийн бүртгэл баталгаажина. Мөн тэд компанийн санхүү, үйл ажиллагааны мэдээллийг цаг тухайд нь авах боломжтой болно” гэж ярьсан. Тэгэхээр “Эрдэнэс Тавантолгой” хувьцаа өгч байна гэж иргэдийн тархийг

өч төчнөөн жил угаалаа. Зөвхөн иргэд гэлтгүй аж ахуйн нэгжүүдийг хүртэл хулхидсан. 2007 онд ЭТТ компанийн хувьцааг нээлттэй худалдахад үндэсний 533 ААН худалдан авсан юм. Тэд нийт 7.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг “Эрдэнэс Тавантолгой”-д оруулжээ. Гэвч эдгээр компани өнөөг хүртэл ямар ч ногдол ашиг хүртээгүй сацуу тэр мөнгийг хэрхэн, яаж зарцуулсан тайлан ч байдаггүй аж. Иймд ААН-үүд нэгдэн, “Монгол 999 үндэсний нэгдэл”-ийг байгуулсан. Улмаар дээрх асуудлыг ярьж, хэлсээр байгаа. Сая ч гэсэн хувьцаа эзэмшигчдийн хурал дээр хуульч Б.Баяр “Эрдэнэс

Тавантолгой” ХК атлаа нээлттэй эсвэл хаалттай юу гэдэг нь тодорхойгүй хэвээр байна. Хөрөнгийн биржид бүртгүүлэн, хувьцаа гаргаж, хувьцаагаа арилжиж эхэлснээр нээлттэй ХК болдог. Харин Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгүүлснээр хаалттай ХК болдог. Гэтэл эдгээрийн алинд нь ч бүртгэлгүй тул компанийн статусыг шийдвэрлэх, үүний тулд компанийн дүрэмдээ өөрчлөлт оруулах нь зөв” гэсэн санал гаргасан байна билээ. Түүнээс гадна тус компанийн хувьцааг эзэмшдэг 2.5 сая иргэнийг төлөөлж, ТУЗ-д нэг иргэнийг томилох саналыг

хуралд оролцогч гаргасан юм билээ. Гэвч С.Түмэнцогт дарга хүлээж аваагүй байсан. Тус компанийн нийт хувьцааны 14 хувийг иргэд эзэмшдэг шүү дээ. Ядаж байхад “Эрдэнэс Тавантолгой”-н “амьтай” нэг ч хувьцаа байхгүй баймаар. Иргэд хувьцаа нь амилаагүй гээд ногдол ашиг өгдөггүй. ААН-үүдэд хүртэл. Тэгээд хэний хувьцаа “амьтай” болоод тэд хувьцаа эзэмшигчдийн хурал гэж хийгээд байгааг ч бас ойлгохгүй байна. Энэ асуудлыг нэг гишүү нь болгож, шийдвэрлэх төр засаг, хууль, шүүх гэж байна уу ингэхэд. Иргэд асуудлыг гаргаад, шүүхэд өгөөд байхад тэд яагаад огт тоохгүй байна вэ.

# ОРОН НУТАГ

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ



## Н.МӨНХБАЯР: МАНАЙ ХАМТ ОЛОН ШУУРХАЙ ҮЙЛЧЛЭХЭЭР ЦАЙНЫ ЦАГГҮЙ

Л.БУЯНХИШИГ

*Дархан-Уул аймгийн Эрүүл мэнд нийгмийн даатгалын байгууллага үүсч хөгжсөний 75, хэлтсийн 55 жилийн 2017 оны дөрөвдүгээр сарын 28-нд тохиосон билээ. Ойг тохиолдуулан Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Н.Мөнхбаяртай ярилцлаа.*

**-Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллага үүсч хөгжсөний түүхтэй ой болж өнгөрлөө. Ойн хүрээнд ямар ажлуудыг хийж, хэрэгжүүлэв?**

-Бид байгууллагынхаа ойг

баяр ёслол гэдэг үүднээс тэмдэглэхийг хүсээгүй. Харин шинэ байртай болсных өрөө тасалгаа, гадна орчноо тохижуулж дуусгахаас эхлээд хийх зүйл их байлаа. 2017 оныг салбарын хэмжээнд "Эерэг хандлага-чанартай үйлчилгээ"-ний жил болгон зарласантай холбогдуулан бид "Чанартай үйлчилгээ-соёлтой харилцаа" сэдэвт 75 хоногийн аян зохион байгуулж, ажилтнуудын хариуцлага, сахиулгыг сайжруулах, ёс зүйг дээдэлсэн соёлч үйлчилгээг нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна. Мөн хэлтсийн 55 жилийн ойг угтан Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015

стандартыг нэвтрүүлэхээр ажиллаж байгаа. Мөн үйл ажиллагааг сайжруулах 75 шинэ санал, санаачилга гаргаж, бүтээлч ажил хийнэ.

**-Аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс хэчнээн албан хаагчтай, ямар ямар чиглэлийн үйлчилгээг даатгуулагчдад үзүүлж байна вэ?**

-Манай хэлтэс батлагдсан орон тооны хүрээнд нийт таван тасаг, 46 орон тоотойгоор ажиллаж байна. Бид 2016 оны дөрөвдүгээр улирлын байдлаар нийгмийн даатгалын шимтгэл болон эрүүл мэндийн даатгалын хураамжаар 38872.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 39781.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 908.1 сая төгрөгөөр давуулж төлөвлөгөөгөө 102.2 хувьтай биелүүлсэн. Харин энэ оны эхний улирлын байдлаар 9324.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 9789.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 105 хувьтай байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын хувьд өнгөрсөн оны аравдугаар сарын 01-ний байдлаар 608 ажил олгогчийн 4015.7 сая төгрөг болсон учраас ажил олгогчдод тавих шаардлагыг өндөржүүлж, өр авлагыг жилийн эцэст 2929.9 сая төгрөгт хүргэн бууруулан



Аймаас мэдээлж байна

ДОРНОГОВЬ АЙМАГ

### "Соёл, аялал жуулчлалын өдөрлөг" анх удаа Эрээн хотод зохион байгуулагдв

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хот, Дорноговь аймгийн хамтын ажиллагааны хүрээнд орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадвартай импортыг орлох, экспортын баримжаатай дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэвшилтэт техник, технологи, туршлага судлуулах хөрөнгө оруулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор энэ сарын 23, 24-ний өдрүүдэд Дорноговь аймгийн "Соёл, Аялал жуулчлалын өдөрлөг" Эрээн хотод боллоо. Өдөрлөгийн үйл ажиллагаанд Сайншанд, Замын-Үүд, Эрдэнэ, Улаанбадрах, Дэлгэрэх зэрэг сумын 60 гаран жижиг дунд бизнес эрхлэгчид мах, махан бүтээгдэхүүн, цагаан идээ, арьс ширэн эдлэл, үндэсний хувцас болон ноос ноолууран бүтээгдэхүүн, бэлэг дурсгал, уран зураг, сийлбэр, монгол гэр зэрэг олон бүтээгдэхүүнээр оролцож, жижиг, дунд бизнес эрхлэгчидэд энэхүү үзэсгэлэнгээр 40 орчим сая төгрөгийн борлуулалт хийсэн юм. Харин аялал жуулчлалын компани, зочид буудал, ресторан, Бүрдэнэ булаг, Халзан уулын амралтын газар зэрэг 20 гаруй байгууллагуудын төлөөлөл өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчлан танилцууллаа. Ирэх есдүгээр сард Дорноговь аймаг хамтын ажиллагаатай Бугат хотод энэ чиглэлийн өдөрлөгийг зохион байгуулахаар төлөвлөж байна.

### "Хаврын мод тариалалт"-ын нээлт Хамрын хийдэд боллоо

Дорноговь аймгийн Сайншанд сумын нутаг Хамрын хийдэд "Хаврын мод тариалалт"-ын нээлт боллоо. Тодруулбал, аймгийн Засаг даргын "Хөгжлийн төлөө хамтдаа" үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан дэвшилтэт техник технологи, инновацийг нэвтрүүлж, ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлж, аймгийн хэмжээний ногоон байгууламжийг гурав дахин нэмэгдүүлэн газрын доройтлыг бууруулж, цөлжилтийг сааруулахын тулд тэргүүлэх зорилт болгон дэвшүүлсэн билээ. Тэгвэл энэ ажлын хүрээнд аймгийн хэмжээнд "Ирээдүй хойч үедээ цэнгэг агаар, эрүүл амьдралыг бэлэглэе" уриаг дэвшүүлж, "Хаврын мод тариалалт"-ыг Хамрын хийдээс эхлүүлсэн нь энэ ажээ.

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

## НАЛАЙХ ДҮҮРЭГТ 50 ОРТОЙ ХҮҮХДИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ШАВЫГ ТАВИЛАА

О.АНИР

БНХАУ-ын "Энхтайван хөгжлийн сан"-гийн 100 хувийн хөрөнгө оруулалтаар Налайх дүүрэгт баригдах Хүүхдийн нэгдсэн эмнэлгийн шавыг өнгөрсөн баасан гарагт тавилаа. Энэхүү арга хэмжээнд Монголын талаас НИТХ-ын төлөөлөгч С.Амарсайхан, "Хангарьд-Улаанбаатар" ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Ганбаяр, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга Л.Төмөрбаатар, Налайх дүүргийн Засаг дарга З.Раднаабазар нар оролцсон бол хөрөнгө оруулагч талаас БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын Элчин зөвлөх Яан Чиндун, Гуравдугаар нарийн бичгийн дарга Хуан Жун, Боловсрол хариуцсан мэргэжилтэн Хүчирхэг нарын бусад албаны хүмүүс оролцсон юм. 50 ортой тус эмнэлгийн бүтээн байгуулалтыг энэ оны аравдугаар сард дуусгахаар төлөвлөж байгаа ажээ. Энэ талаар БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын Элчин зөвлөх Яан Чиндун "БНХАУ-ын "Энхтайван хөгжлийн сан" болон шат шатны байгууллагуудын дэмжлэг туслалцаатайгаар дахин нэг амжиргааны төслийн бодит хэрэгжилт Налайх дүүрэгт бий болох гэж байна. Бидний хамтын хичээл зүтгэлээр баригдсан энэхүү нэгдсэн эмнэлгээрээ дамжуулаад Налайх дүүргийн хүүхэд багачуудад чанарын шаардлага хангахуйц эмчилгээ, үйлчилгээг хүргэхийг бид зорьж байгаа. Энэхүү нэгдсэн эмнэлгийг таван сарын дотор дуусгахаар төлөвлөж байгаа" гэлээ.

Налайх дүүргийн Нэгдсэн эмнэлгийн хувьд хүүхдийн түргэн тусламжийн үйлчилгээгүй бөгөөд тус эмнэлгийн Хүүхдийн тасгийн хүлээн авах хэсгээр хоногт дунджаар 20-30 хүүхэд үйлчлүүлдэг байна. Мөн тус дүүргийн хүүхдийн тасаг, гэрх тасаг тусдаа байдгаас төрөх хүүхдийн тасагт ажиллах нярайн

...Энэ эмнэлэг ашиглалтад орсноор Налайхын хүүхэд багачуудад үйлчлээд зогсохгүй нийслэлийн алслагдсан дүүрэг гэгддэг Багахангай, Багануур дүүргийн бүх хүүхдийг хүлээн авч эмчлэх давуу талтай" гэж ярьсан юм...



эмч дутагдалтай, шаардлагатай тоног төхөөрөмж байдаггүй зэрэг асуудлуудыг салбарын эмч, мэргэжилтнүүд учирлаж байсан юм. БНХАУ-ын "Энхтайван хөгжлийн сан" 2012 оноос хойш Монгол Улстай хамтран

эмчилгээ, боловсрол, ажилчдын сургалт болон хэвлэл мэдээллийн салбарт ард түмэнд хүртээмжтэй цуврал төслүүдийг хэрэгжүүлж байгаа бөгөөд шав тавих ёслолын ажиллагаа гурав дахь хамтын үйл ажиллагааны нээлт гэдгээрээ

онцлог боллоо. Мөн НИТХ, Нийслэлийн иргэдийн хурлын Төсвийн байнгын хорооны дарга С.Амарсайханы хувьд энэхүү төслийг санаачлан, хэрэгжүүлж байгаа юм. Тэрбээр "Налайх хэдийгээр нийслэлийн дүүрэг

боловч эмчилгээ үйлчилгээ, эрүүл мэндийн оношилгооны хувьд хүрэлцээ муутай байдаг. Энэ асуудлыг шийдвэрлэх үүднээс 50 ортой хүүхдийн эмнэлэг барих санаачлага гаргаж, өөрийн болоод БНХАУ-ын "Энхтайван хөгжлийн сан"-гийн хөрөнгө оруулалт, дэмжлэг туслалцаатайгаар барьж байгуулах ажлыг "Хангарьд-Улаанбаатар" ТББ-ын хамтын ажиллагаатайгаар эхлүүлж байна. Энэ эмнэлэг ашиглалтад орсноор Налайхын хүүхэд багачуудад үйлчлээд зогсохгүй нийслэлийн алслагдсан дүүрэг гэгддэг Багахангай, Багануур дүүргийн бүх хүүхдийг хүлээн авч эмчлэх давуу талтай" гэж ярьсан. Харин "Хангарьд-Улаанбаатар" ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Ганбаяр "Бид Боловсролын салбарт БНХАУ-ын "Энхтайван хөгжлийн сан", БНСУ-ын Койка болон бусад олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллаж байгаа. Яг "Энхтайван хөгжлийн сан"-тай хамтарч, тус сангийн 100 хувийн хөрөнгө

орлуулалтаар 2015 оны 11 дүгээр сард Чингэлтэй дүүргийн 15 хороо буюу Хайлаастын хуучин эхсийн буудлын хажууд Хүүхдийн амбулаторийг барьж ашиглалтад оруулсан бол 2016 онд Төв аймгийн Зуунмод хотод 250 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг барьж, хүлээлгэн өгсөн. Энэ жилийн хувьд Налайх дүүрэгт 50 ортой, алсын гурван дүүргийн хүүхэд багачуудад үйлчлэх нэгдсэн эмнэлгийг барихаар ийнхүү шавыг нь тавьж байна. Бидний хувьд 2020 он гэхэд нийслэлийн бүх дүүрэгт Хүүхдийн эмнэлэг барьж, байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байгаа" гэж ярила. Энэхүү нэгдсэн эмнэлгийг байгуулснаар хүүхдийн орны хүрэлцээ сайжирч, иргэдийн хот руу явуулдаг чирэгдэл багасахаас гадна эмч мэргэжилтнүүдийн ажиллах орчин сайжирч, эмчилгээ үйлчилгээ үзүүлэхэд саадгүй болох давуу талтай хэмээн албаныхан онцолж байлаа.

# ОРОН НУТАГ

ажилласан. 2017 оны нэгдүгээр улирлын байдлаар “Шарын гол” ХК 580.1, “Дархан-Ус суваг” ХК-ийн 369.0, “Эрэл цемент” ХК-иас 181.6, “Газар хэвлий” ХХК 74.6, “Дулаан шарын гол” ХК 67.3 сая төгрөгийн авлагатай байна.

**-Аймгийн хэмжээнд**

**хэрхэн тэгш хүртээмжтэй олгож байна вэ?**

Хөнгөлөлттэй олгодог эмийг иргэд, даатгуулагчдад тэгш хүртээмжтэй олгох зорилгоор аймгийн Ахмадын хороо, Эрүүл мэндийн газар, Эмийн холбоо, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн

нягтлан шалгахад үндэслэлгүй баримтаар тогтоосон, хуулийн заалт буруу хэрэглэснээс дөрвөн хүний 4.8 сая төгрөгийн тэтгэврийг тус тус төлүүлэх, есөн хүний 4.7 сая төгрөгийн тэтгэврийг нөхөн олгохоор шийдвэрлэсэн. Нийт 206 даатгуулагч банкаа сольсон байна. Үүнд, Хаан банк 127, Төрийн банк 23, Чингис хаан банк 46, Капитал банк 10, тэтгэвэр урьдчилан авсан дөрвөн хүнд 1.5 сая төгрөг олгосон.

**-Иргэд, даатгуулагчдад түргэн шуурхай, хүнд сурталгүй үйлчилгээг үзүүлэх нь төрийн албан хаагчдын үүрэг байдаг. Энэхүү үүргээ та бүхэн хэрхэн биелүүлж байна вэ?**

Нүүдлийн хурлыг улирал тутам Шарын гол суманд зохион байгуулж, алслагдсан сумын иргэдэд байнга сургалт зохион байгуулж байна. Манай хамт олон иргэд, даатгуулагчдад түргэн шуурхай

шат дараатай зохион байгуулж, ур чадвар, мэдлэг боловсролыг нь дээшлүүлсэн.

**-Нийгмийн даатгалын тухай хуулиудад ямар, ямар нэмэлт өөрчлөлт орсон бэ?**

-Засгийн газрын 2016-2020 оныүйлажиллагааныхөтөлбөрт тусгагдсанхөдөлмөр,нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх зорилгоор УИХ, ЗГ, ХНХЯ-аас хууль эрх зүйн орчныг сайжруулах, иргэдийнхээ хэрэгцээ шаардлаганд нийцүүлэх үүднээс 60, түүнээс дээш настай эрэгтэй, 55 түүнээс дээш настай эмэгтэйчүүдийг хамруулсан “Ахмад настны тухай хууль”, Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуулиудыг шинэчлэн найруулж батлуулсан. “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-д цэргийн алба хаагч энгийн байгууллагад ажилласан нэг жилээ цэргийн байгууллагад зургаан сар ажилласнаар шилжүүлэн



*Аймаас мэдээлж байна*

**БУЛГАН АЙМАГ**

**“Хөгжлийн хөтөч” үйл хөтөлбөрийн нээлт боллоо**

2016-2020 онд Булган аймгийн засаглал, эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг зүгийг тодорхойлох Булган аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч” үйл ажиллагааны хөтөлбөрийн дэд хөтөлбөрүүдийнхээ гарааг ард иргэд, гардан хэрэгжүүлэх баг хамт олонтойгоо хамтдаа нээлээ. “Булган - жимс, жимсгэнэ”, “Оюунлаг Булган”, “Эрүүл мэндийн хөтөч”, “Уртын дуу-Морин хуур”, “Монгол нум сум”, “Эрүүл ирээдүй”, “Зөв бүртгэл”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр”-үүдээ зөв зохион байгуулалттай, хариуцлагатай удирдлагын тогтолцоогоор үр дүнтэй хэрэгжүүлсэнээр, хөгжлийн тулгуур хүн, өрх гэр бүлийг хөгжүүлэх, аймаг, сумын хөгжил, айл өрхийн амьдралын түвшинг дээшлүүлж, ажиллаж, амьдрах нөхцлийг сайжруулна гэж үзэж байна. Булган аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч” үйл ажиллагааны хөтөлбөрийн дэд хөтөлбөрүүдийн нээлтэнд 16 сум, нэг тосгоноос хүрэлцэн ирсэн салбар, салбарын төлөөлөл 1000 гаруй иргэн, төрийн албан хаагчид оролцлоо. Тус хөтөлбөрүүдийн үр дүн шинээр бий болгосон ажлын байр, нийгмийн салбарын бүтээн байгуулалт, Булган нутгийн иргэдийн амьдралын чанар, сэтгэл ханамжаар хэмжигдэнэ гэдгийг аймгийн Засаг дарга хэлсэн үгэндээ онцлолоо. Мөн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд шаг дараалсан сургалтуудыг зохион байгуулж байна.

**ДОРНОГОВЬ АЙМАГ**

**30мвт хүчин чадалтай нарны цахилгаан станцын шав тавих ёслол боллоо**



Дорноговь аймгийн Сайншанд хотод баригдах Монголын хамгийн том 30Мвт хүчин чадалтай нарны цахилгаан станцын шав тавих ёслолын ажиллагаа энэ сарын 27-нд боллоо. Ёслолын ажиллагаанд аймгийн ИТХ-ын дарга С.Түмэнбаяр, аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин, “Дезерт Солар Пауэр Буан” ХХК-ий захирал Э.Батзаяа, Хавиер Лопез Зарраконос нар болон холбогдох албаны хүмүүс оролцсон юм. Тус нарны цахилгаан станцыг Сайншанд сумын 3-р багийн нутаг дэвсгэрт 714000м.кв талбайд барих бөгөөд энэ хүрээнд түр болон байнгын 150 гаруй ажлын байр шинээр бий болно. Мөн станц нь жил бүр 52,276 сая киловатт цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэн төвийн эрчим хүчинд нийлүүлэх юм байна. Нарны цахилгаан станцыг барих ажил ирэх тавдугаар сард эхлэх бөгөөд энэ ондоо багтаан барьж дуусгахаар төлөвлөдөг байна. Мөн аймгийн төв талбайд зохион байгуулагдсан төрийн байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн үеэр “Дезерт солар пауэр буан” ХХК аймгийн Засаг даргатай байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээний дагуу орон нутгийн иргэдээс бүтээн байгуулалтын ажилд орон нутгаас авах боломжтой хүний нөөцөө бэлтгэх зорилгоор нээлттэй ажлын байранд бүртгэл хийхээс гадна нийгмийн халамж шаардлагатай таван өрхөд гэр олгож дэмжлэг үзүүлсэн юм.

**ОРХОН АЙМАГ**

**“Нийгмийн эрүүл мэндийн төв” байгуулна**

“Улсын хөгжлийг ярьж гэвэл хүний хөгжлийг, хүний хөгжлийг ярьж гэвэл эрүүл мэндийн асуудлыг ярих хэрэгтэй” хэмээн Орхон аймгийн Засаг дарга Д.Батлут Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал Б.Цогтбаатарыг хүлээн авч уулзах үеэрээ хэллээ. Мөн нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй зарим асуудлаа танилцуулсан юм. Тухайлбал, хөнгөлөлттэй үнээр олгох эмийн санхүүжилтийг өмнөх оныхоос 30 хувь нэмэгдүүлж 850 сая төгрөг, хувийн эмнэлгүүдэд Нийгмийн даатгалын сангаас олгодог санхүүжилтийг нэг тэрбум 43 сая төгрөг болгосон байна. Түргэн тусламжийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй, чанартай хүргэх зорилгоор Орхон аймгийн хэмжээнд “Түргэн тусламжийн төв” байгуулах саналаа ЭМЯ-д хүргүүлжээ. Уг төв байгуулагдсанаар 20 минутын хугацаанд түргэн тусламжийн бүх дуудлагад хүрч үйлчилнэ гэж тооцож байгаа юм. Орхон аймгийн БОЭТ-ийн амбулаториор үйлчлүүлж буй нийт иргэдийн 41 хувь нь өвчний улмаас ханддаггүй буюу ажилд орох, хүүхдийн зусланд амрах, эрүүл мэндийн чөлөө авах, жолооны үнэмлэх авахад шаардагдах бичиг авах зорилгоор хандсан байдаг байна. Энэ нь үзлэг оношилгоонд хамрагдахаар ирсэн өвчтөнтэй дугаар болон цаг булаацалдаж хүндрэл учруулдаг. Иймд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх болон дээрхтэй холбоотой асуудлыг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн “Эмнэлэг сувилалын алба”-д шилжүүлж ажиллалал оновчтой гэж ЭМГ-ын дарга М.Баттүвшин хэллээ. Энэ асуудлыг үйлдвэртэй гэрээ хийхдээ ярьж оновчтой хувилбарыг гаргаж гэж Засаг дарга Д.Батлут онцлолоо. Түүнчлэн “Элэгний вирусгүй Эрдэнэт” аяныг 2016 оны есдүгээр сараас хэрэгжүүлж албан байгууллагууд ажилчидаа элэгний В, С, Д вирус илрүүлэх шинжилгээ өгч вакцинд хамруулж эхэлсэн байна. В, С вирустай эхээс төрсөн хүүхдэд вакцин хийхэд орон нутгаас анх удаа 30 сая төгрөг төсөвлөжээ. Мөн “Нийгмийн эрүүл мэндийн төв” байгуулахад орон нутгаас 98 сая төгрөг төсөвлөсөн нь орон нутгийн удирдлагууд иргэдийн эрүүл мэндэд хэрхэн анхаарч ажиллаж байгаагийн илрэл гэж Эрүүл мэндийн газрын дарга М.Баттүвшин онцолсон юм. Мөн Монгол Улсын гавьяат дөрвөн эмч иргэдэд үнэ төлбөргүй үзлэг, оношилгоо хийж байна. Монгол Улсад тохиолдож буй нийт өвчлөлийн 10 хувь нь удамшлын, 10 хувь нь эрүүл мэндийн байгууллага, 25 хувь нь орчны эрүүл ахуй, 55 хувь нь тухайн иргэний амьдралын хэв маяг, зан үйртэй холбоотой байна гэж Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Б.Цогтбаатар хэллээ. Иймд Орхон аймаг хүн амын эрүүл мэндийн асуудлаа соргоогоор харж олон ажил эхлүүлж, хүний хөгжилд анхаарч байгаад талархаж байна гэсэн юм.

## ИРГЭД, ДААТГУУЛАГЧДАД ТҮРГЭН АЖИЛЛАХ САНААЧИЛГА ГАРГАСАН

**хэчнэн иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүргэх орчинг бүрдүүлсэн бэ?**

Нийт 51069 иргэнд эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төрөөс хариуцан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг. Албан хаагчдын санаачилгаар зорилгот бүлгийн иргэдэд ЭМД-ын дэвтэр үнэ төлбөргүй олгох ажлыг тогтмол зохион байгуулж ирлээ. Оны эхний нэгдүгээр улирлын байдлаар ЭМД-ын сангаас 29732 даатгуулагч 1562.4 сая төгрөгийн эмчилгээ, үйлчилгээний зардал авсан байна. Ажил, хөдөлмөр эрхлээгүй 4200 орчим иргэн, 340-өөд малчин, 660 гаруй оюутныг эрүүл мэндийн даатгалд хамруулж, эрүүл мэндийн даатгалын санд 171.3 сая төгрөгийн орлогыг тус тус хуримтлуулсан байна.

**-Хэлтсийн дэргэдэх ЭХМК нь 2017 оны нэгдүгээр улиралдхэдэнудаахуралдаж, хэчнэн даатгуулагчдад хүрч ажиглав?**

Хэлтсийн дэргэдэх ЭХМК нь энэ оны нэгдүгээр улиралд 13 удаа хуралдаж, нийт 1013 даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгах, тогтоох, цуцлах хөдөлмөрийн нөхцлийг солх шийдвэр гаргасан. Нийт 377 иргэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хугацаагүйгээр тогтоолгосны 312 иргэнийг дахин магадлан хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгаж 82.5 хувьтай ажиллалаа.

**-Хөнгөлөлттэй эмийг иргэд, даатгуулагчдад**

оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн дүнд хамтран ажиллах ажлын хэсэг байгуулж, энэ онд хийх зорилгоо тодорхойлж, ажлын төлөвлөгөөгөө гарган ажиллаж эхэлсэн. 10 нэр төрлийн 30 эм бэлдмэлийн үнийг эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувь хөнгөлдөг болсонтой холбоотойгоор гуравдугаар сарын 31-ний байдлаар 67.4 мянган хүүхэд нэг тэрбум төгрөгийн эмийг үнэгүй аваад байна.

**-Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагад аймгийн Аудитын газраас 2016 онд шалгалт хийсэн. Ямар, ямар зөвлөмж хүргүүлсэн бэ. Түүнийг хэрхэн хангаж ажиллаж байна вэ?**

Аймгийн Аудитын газраас хийсэн 2016 оны байгууллагын үйл ажиллагааны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлттэй дүгнэгдсэн. Далайхан Аудит нийгмийн даатгалын сангийн жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийсэн. Харин аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба гуравдугаар сарын 20-нд манай хэлтсийн үйл ажиллагааны 2015-2016 оны тайланд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллалаа. “Тэтгэвэр тогтоолт, олголт шалгах” аяны хүрээнд дөрвөн сумын нийт 13719 тэтгэвэр авагчийн хувийн хэргийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгаж, ажлын гүйцэтгэлийг 100 хувьтай хийж гүйцэтгэлээ. Тэтгэврийн хувийн хэргийг

үйлчлэхээр цайны цаггүй ажиллах санаачилга гаргаж, энэ оны гуравдугаар сарын 01-нээс эхлэн хэрэгжүүлж байна. УИХ-ын гишүүдийн иргэдтэй хийсэн найман удаагийн уулзалтын үеэр Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчиллаа. Хэлтсийн албан ёсны dark-han-ndaatgal.gov.mn цахим хуудсыг шинэчилж, иргэд даатгуулагч, ажил олгогчдод мэдээ мэдээллийг цаг алдалгүй хүргэж байна. 2016 онд есөн байцаагч дотоод сүлжээний мессенжер буюу инбит эрхтэй ажиллаж байсан бол энэ онд 39 байцаагчид эрх нээж, нэр хаяг, нэршлийг стандартын дагуу болгон шинэчиллээ. Түүнчлэн аймгийн Darkhan.gov.mn вэб сайт, орон нутгийн телевизүүдтэй хамтран ажиллаж, мэдээ мэдээллийг олон удаагийн давтамжтайгаар иргэдэд шуурхай хүргэж байна.

**-Нөгөө талаас албан хаагчдаа хөгжүүлэх, тэдэнд чиглэсэн сургалтыг хэрхэн явуулж байна вэ?**

2017 онд нийт байцаагч, ажилтнуудынхаа харилцаа хандлага, ур чадварыг сайжруулах зорилтын хүрээнд “Хувь хүний манлайлаг”, “Илтгэх урлаг ба багаар ажиллах чадвар”, “Бие хүний хандлага чухал болох нь”, “Албан хэрэг хөтлөлт найруулга зүй”, “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө,орлогын мэдүүлгээ хэрхэн оруулах, мэдүүлэг өгч буй албан хаагчдын түгээмэл алдаа, түүнээс урьдчилан сэргийлэх нь” сургалтуудыг

тооцуулж, тэтгэвэр тогтоологч боломжийг нээж өгсөн. Мөн нийгмийн даатгалын шимтгэл төлөлт нь 1995-2016 онд тасарсан малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчид тэтгэврийн даатгалын шимтгэлийн тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 10 хувиар тооцож, нэг удаа нөхөн төлөх эрхтэй болж байна. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч нь 1995-2016 оныг бүрэн хамруулан төлбөл нэг удаа 1.9 сая, харин 2001-2010 оныг хамруулан нөхөн төлбөл 727.3 мянган төгрөг тус тус төлөхөөр болсон. Энэхүү Малчин хувиараа хөдөлмөр эрхлэгчид тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль 2018 оны нэгдүгээр сараас эхлэн хэрэгжинэ. Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн ээжүүдийн хөдөлмөрийг бодитой үнэлэхийн зэрэгцээ малчдын тэтгэврийн насыг таван жилээр наашлууллаа. Тэтгэврийн зээлийн хүүг бууруулж, иргэд тэтгэвэрээ урьдчилж хүүгүй авах бас өөрсдөө банкаа сонгодог боллоо. “Эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай хуулийг мөн л 2018 оны нэгдүгээр сараас эхлэн хэрэгжүүлнэ. Мөн 15-34 насны залуучуудын нийгмийн хөгжилд оролцох оролцоог тодорхойлж, төрөөс залуучуудад дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилготой “Залуучдын хөгжлийг дэмжих тухай хууль”-ийн төслийг УИХ-аар хэлэлцэж байна. Уг хууль нь Залуучуудын хөгжлийн талаархи анхны хууль болж байгаагаараа онцлогтой.



### БАТСҮМБЭРТ 100 ҮНЭЭНИЙ ФЕРМ ЗАРНА



Төв аймгийн Батсүмбэр сумын 324 дүгээр зогсоолын Үдлэг багт байрлалтай 100 үнээний багтаамжтай, өөрийн гүний худаг, 380v цахилгааны эх үүсвэр болон усалгааны системийн хажууд байрлах 7800м2 газартай, 14.2м өргөн, 47м урттай блокоор барьж, тоосгоор өнгөлсөн 64-ийн ханатай, орчин үеийн шийдэлтэй үнээний ферм зарна.

**Үнэ: 200.0 саяас**  
**Хобогдох утас: 99057278**

# ЗАВСАРЛАГА

ДУУЛГАХ СОНИН

## "Алтан агсарга" - 60 ЭЗЭД ТОДРОВ

Н.ЗАЯА

Шинжлэх ухаан, соёл урлагийн шилдгүүдэд олгодог "Алтан агсарга" шагнал гардуулах ёслолын үйл ажиллагаа энэ сарын 27-нд болов. Энэхүү ёслолын үйл ажиллагааг Үндэстний соён гэгээрлийн "Алтан агсарга" нийгэмлэгээс зохион байгууллаа. Тус нийгэмлэг нь Тус нийгэмлэг нь шинжлэх ухаан, соёл урлагийн салбаруудад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн судалгаа шинжилгээ, соёл урлагийн бүтээл, туурвил гаргасан монгол угсаатан эрдэмтэд, судлаачид, уран бүтээлчид, соёлын зүтгэлтнүүдийн үйл ажиллагааг дэмжин тэтгэх, урамшуулан алдаршуулах, нийгэм, эдийн засгийн бусад салбарууд дахь дэлхийн Монголчуудын хамтын ажиллагааг үүсгэн өргөжүүлж дэмжих зорилготой аж.

"Алтан агсарга" нийгэмлэгийн бодлогын зөвлөлд Ардын уран зохиолч, яруу найрагч Б.Лхагвасүрэн, Ардын жүжигчин Хөгжмийн зохиолч Н.Жанцанноров, гэвш Д.Нямсамбуу, түүхч С.Чулуун, их аварга Д.Дагвадорж найруулагч Б.Баатар нарын ахмад залуу гурван үеийн төлөөлөлүүд багтсан гэнэ. "Монгол тулгатны 100 эрхэмүүд"-ээс бүрдсэн уг нийгэмлэгийн

бодлогын зөвлөлийн гишүүд их чуулганаар бодлого төлөвлөлтөө хэлэлцүүлэн батлуулах бүтэцтэйгээр ажиллахаар болжээ. Үндэстний Соён гэгээрлийн "Алтан агсарга" нийгэмлэгийн гишүүнчлэл нь тус нийгэмлэгийн үйл ажиллагааг дэмжин оролцох гадаад дотоодын байгууллага хувь хүн бүрт нээлттэй болохыг нийгэмлэгийн бодлогын



зөвлөл онцлон дурьдав. Мөн тус нийгэмлэгээс олон улсын монгол судлалын холбооны үйл ажиллагааг дэмжин, чансаа ач холбогдлоороо шалгарсан гадаад дотоодын монголч эрдэмтдийн судалгаа бүтээлүүдэд "Алтан агсарга" шагналыг олгох юм. Энэхүү шагнал нь эрдэнийн чулуу шигтгээтэй алтан бүс болон



мөнгөн шагналаас бүрдэх гэнэ. Олон улсын Монгол судлалын холбоо нь 1959 онд Улаанбаатар хотноо Цэндийн Дамдинсүрэн, Бямбын Ринчин, Хангин Гомбожав Оуэн Латтимор нарын нэрт эрдэмтдийн үүсгэл санаачлагаар голломтоо бадрааж эдүгээ Европ, Ази, Австрали, Америк тивийн 27 улсын 100 гаруй их



сургуульд салбар төвтэй болжээ. Түүнчлэн ллон зуун эрдэмтэн судлаачдын судалгаа бүтээлүүдээрээ дэлхий дахинд Монгол Улс, үндэстнийг таниулан сурталчилдаг байна. Монгол Улсад төвтэй Монгол судлалыг хүчтэй хөгжүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулах нь монгол хүн бүрийн бахархалт үүргээр зогсохгүй өнөөдрийн

нийгэм, улс төрийн тулгамдсан асуудлуудыг оновчтой шийдэхэд төр засгийн холбогдох институциуд болон олон улсын ба дотоодын хөрөнгө оруулагчдад шийдвэр гаргахад нь туслах суурь судалгааны орчинг бүрдүүлдгээрээ нийгэмд ач холбогдолтой гэдгийг энэ үеэр эрдэмтэд онцолж байлаа.

Улаанбаатарт:

Маргааш  
Өдөр -11  
Шөнө -16

Нөгөөдөр  
Өдөр -14  
Шөнө -23

### Өдрийн зурхай

**ХАВАРЫН ДУНД ХАРАГЧИН ТУУЛАЙ САРЫН НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАР МОРЬ ӨДӨР**

Үс засуулбал: Эд, мал арвижна  
Наран ургах, шингэх: 06:30-19:20



Арвын тооллын 4 сарын 1, Санчир гараг. Билгийн тооллын 5, Чөлөөт эх одтой, шар морь өдөр. Өдрийн наран 6 цаг 31 минутад мандан, 19 цаг 20 минутад жаргана. Тухайн өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба гахай, хулгана жилтнээ сөрөг луу нөлөөтэй тул элдэв үйлд хяналгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлд шалдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, зэрэг дэвших, угаал үйлдэх, танараг тавих, гэр, байшингийн суурь тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэлцэл хийхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, торь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод хойш төрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлэх буюу засуулбал эд, мал арвижна.

СОНИРХУУЛАХАД

## Энэрэл хүүг илүү тоогоор биднийг харахаг нь туслаарай

Эгдүүтэй төрх, эвлэгхэн хоолойгоороо үзэгчдийн дунд аль хэдийнэ өөрийн гэсэн сонсогчидтой болсон бяцхан хүү Б.Бат-Энэрэлд зориулсан хандивын тоглолт зохион байгуулагдах гэж байна. МУГЖ, дуучин С.Батсүхийн "Орчлонг хайрлаарай", "Ухаарал" зэрэг дууг тун ч хөөрхөн дуулж олны хайр хүндэтгэлийг хүлээгээд байгаа бяцхан дуучин маань төрөлхийн харааны бэрхшээлтэй төрсөн ч нэг настайгаасаа сул хардаг болсон гэнэ. Мэргэжлийн эмч нар хүүг зургаан нас хүрэхээс урьтаж мэс заслын аргаар харааг нь сайжруулах боломжтойг зөвлөснөөр Энэтхэг улсад нүдний хагалгаанд орохоор болжээ. Хагалгааны зардалд зориулан гэр бүлийнхний зүгээс хандивын тоглолт зохион байгуулахаар болсон байна. Хандивын тоглолт энэ сарын 20-нд 19.00 цагт МҮЭСТО-нд болох юм. Хандивын аянд зориулан МУГЖ С.Батсүх "Хаан заяатай орчлон" дуугаа Б.Бат-Энэрэл хүүтэй шинэчлэн дуулж, дүржүүлсэн



байна. Энэхүү дууг "Мобиком"-ын хэрэглэгчид "Hitone"-доо татаж тоглуулснаар хүүгийн эмчилгээний зардалд хувь нэмэр оруулах юм байна. Мөн олон нийт бяцхан дуучинд мэлхий хайрлахыг хүсвэл "Хаан" банкны 5005705589 тоот дансанд сэтгэлийн өргөл өргөх боломжтой аж. Бяцхан хүүг С.Батсүх гавьяат өөрийнхөө шавь болгосон бөгөөд багш, шавь хоёрын барилдлагатай болжээ. Дуучин хүү "Хаан заяатай орчлон" дууг дуулахдаа намайг дэмждэг ах эгч нарыгаа илүү тодоор хармаар байна хэмээн хэлдэг нь олон ч хүний сэтгэлд нэгийг бодогдуулсан нь дамжиггүй юм.

КИНО ЕРТӨНЦ

## "Араатны хаан арслан"-д Билли Эйчнер, Сэт Роган нар дуу оруулна

Инээдмийн жүжигчин Сэт Роган, Билли Эйчнер нар Диснейн уран сайхны кино болгон бүтээх дараагийн анимэйшн болох "Араатны хаан арслан" кинонд дуу оруулах гэнэ. Дисней кино компани үзэгчдийн сэтгэлд аль хэдийнэ хоногшин үлдсэн олон хүүхэлдэйн кинонуудыг

уран сайхны кино болгон дэлгэцнээ амилуулж эхэлсэн бөгөөд "Араатны хаан арслан" киног Жон Фавро найруулах билээ. Тэгвэл уг киноны Тимон, Пумба нарын дууг Сет, Билли нар оруулж магадгүй тухай "Варетн" сэтгүүл мэдээлсэн байна. Дашрамд дурьдахад, тус

киноны гол дүр Симбагийн дүрд Доналд Гловер, Муфасагийн дүрд Жэймс Жонс нар тоглох билээ. Жүжигчин Жэймс Жонсын хувьд 1994 онд тус хүүхэлдэйн кинонд дуу оруулж байжээ. Кино 2019 оны долдугаар сарын 19-нд нээлтээ хийнэ.

FOOTBALL NEWS

## Мбаппе топ 5 лигт хамгийн залуудаа 15 гоол орууллаа

Францын Лиг 1-ийн 35 дугаар тойргийн хэрээнд "Монако" клуб талбайдаа "Тулуза"-г хүлээж авч, 3:1-ээр буулгаж авсан билээ. Энэ тоглолтод "Монако"-гийн довтлогч Килиан Мбаппе нэг гоол оруулсан. Ингэснээр 21 дүгээр зуунд хамгийн залуудаа 15 гоолын босго давсан тоглогч боллоо. Тэрбээр 18 нас 130 хоногтойдоо энэ амжилтыг үзүүлсэн юм. Өмнө нь "Манчестер Юнайтед"-ын ахлагч Уэйн Рүүни "Эвертон"-д байхдаа 18 нас 172 хоногтойдоо энэ амжилтыг үзүүлж байжээ.



Бидэнд тохиолдсон

Күнхэн хөгтэй явдлууд  
SuuGii GeGee

Байрныхаа гадаа явж байтал хоёр хүүхэд өөдөөс ирж байв. Тэгсэн цаанаас нь өөр нэг хүү гүйж ирснээ нөгөө хоёр хүүг "Гэртээ орооч" гэж байна. Нөгөө хоёр нь "Хамт тоглох уу. Зоригоо" гэж асуутал аймаар муухай харснаа "Амьдрах гэж талханд явж байна. Юун тоглох нтр" гэдэг байгаа. Хаха. Би талханд гарах гэж яваад замдаа тогложихно. Сүүлд нь талх ч үгүй, мөнгө ч үгүй, зайрмаг долоогоод ордог байсангит хаха

МОНГОЛЫН АВТО МАСТЕРУУДЫН ХОЛБОО  
Замын-Үүд хот